

**АЛБАН ЖУРМЫН ДААТГАЛЫН ТӨРӨЛ, ХЭЛБЭР БА ЭРХ ЗҮЙН ОРЧНЫ ТАЛААРХ
ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ ТУРШЛАГА**

(Харьцуулсан судалгаа)

*Г. Алтан-Оч (Ph.D), И.Жаргалзаяабямба
Д.Жигваагүнсэл, Р.Нургүл, Р.Оргилмаа*

АГУУЛГА

УДИРТГАЛ

СУДАЛГААНЫ ХУРААНГУЙ

АЛБАН ЖУРМЫН ДААТГАЛЫН ТӨРӨЛ, ХЭЛБЭР БА ЭРХ ЗҮЙН ОРЧНЫ ТАЛААРХ
ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ ТУРШЛАГА

- Бүгд Найрамдах Солонгос Улс
- Япон Улс
- Холбооны Бүгд Найрамдах Герман Улс
- Бүгд Найрамдах Азербайжан Улс
- Бүгд Найрамдах Македон Улс

ХАВСРАЛТ

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

УДИРТГАЛ

Судалгаанд гадаад орны албан журмын даатгалын хууль, эрх зүйн зохицуулалтыг судалж, албан журмын даатгалын нэр төрөл, бүтээгдэхүүн үйлчилгээ, холбогдох хууль тогтоомжийн талаар мэдээлэл, лавлагаа гаргуулахыг хүссэний дагуу мэдээллийн хайлт хийж, олдсон мэдээллүүдээс албан журмын даатгалын харилцааг ерөнхий болон тусгайлсан хуулиар тодорхой зохицуулсан зарим орон, тухайлбал, ХБНГУ, БНСУ, Япон, Азербайжан, Македон зэрэг 5 орныг сонгон авч судалсан болно.

СУДАЛГААНЫ ХУРААНГУЙ

Даатгалын харилцаа гэдэг нь гэрээний үндсэн дээр нэг талаас даатгуулагч өөрийн эд хөрөнгө, ашиг сонирхлоо аюул, эрсдэлийн улмаас учирч болзошгүй хохирлыг нөхөн төлүүлэх баталгаатай байх үүднээс тохиролцсон болзлоор урьдчилан даатгуулж, түүний төлөө зохих хураамж төлөх, нөгөө талаас даатгагч нь даатгуулагчид учирч болох хохирлыг бүрэн буюу хэсэгчлэн төлөх үүрэг хүлээж, эрх эдлэх харилцаа юм.

Даатгал нь албан журмын (заавал даатгал) болон сайн дурын даатгал хэмээх үндсэн 2 төрөлтэй байхаас гадна хугацааны хувьд ердийн (1 жил хүртэлх хугацаатай) болон урт хугацааны (1 жилээс дээш хугацаатай) даатгал гэж ангилагдана.

Судалгааны хүрээнд авч үзсэн дээрх 5 орны туршлагаас үзэхэд эдгээр улс орнуудын албан журмын даатгалд тэтгэвэр тэтгэмжийн даатгал, эрүүл мэндийн даатгал, халамжийн даатгал, үйлдвэрлэлийн ослын даатгал, ажилгүйдлийн даатгал, тээврийн хэрэгслийн хариуцлагын даатгал, ажил мэргэжлийн хариуцлагын даатгал, гэнэтийн ослын хариуцлагын даатгал гэх мэт төрлүүдийг нийтлэг хамруулсан байна.

Тухайлсан орнуудын хувьд авч үзвэл:

Холбооны Бүгд Найрамдах Герман Улсад гуравдагч этгээдийг хамгаалах зорилготой даатгалын төрөл болох тээврийн хэрэгслийн даатгал, ажил мэргэжлийн болон анчны хариуцлагын даатгалуудыг албан журмын даатгалд тооцдог. Мөн Хөдөлмөрийн ослын эсрэг даатгалын хуулиар Ажил мэргэжлийн хоршоодыг заавал даатгалд хамруулж, энэхүү хамгаалалтыг төрөөс албадан хэрэгжүүлэхээр зохицуулсан.

Бүгд Найрамдах Солонгос Улсад албан журмын даатгал нь дараах төрөлтэй. Үүнд:

- Тэтгэвэр, тэтгэмжийн даатгал (*National pension insurance*);
- Эрүүл мэндийн даатгал (*National health insurance*);
- Урт хугацааны халамжийн даатгал (*Long term care insurance*);
- Үйлдвэрийн ослын нөхөн олговрын даатгал (*Industrial accident compensation insurance*);
- Ажилгүйдлийн даатгал (*Unemployment insurance*);
- Тээврийн хэрэгслийн албан журмын даатгал (*Compulsory automobile liability insurance*).

Эрх зүйн орчны хувьд албан журмын даатгалын эдгээр төрлүүдийг нийтлэг зохицуулсан хууль, эрх зүйн акт байхгүй бөгөөд даатгалын төрөл тус бүрийг бие даасан хуулиар зохицуулж байна.

Япон улсад албан журмын даатгал нь дараах 4 төрөлтэй. Үүнд:

- Тээврийн хэрэгслийн даатгал (*Vehicle Insurance*);
- Хувь хүний даатгал (*Personnel Insurance*);
- Нийтийн хариуцлагын даатгал (*Public Liability Insurance*);
- Барилга болон эд хөрөнгийн даатгал (*Building and content insurance*) орно.

Эрх зүйн орчны хувьд албан журмын даатгалын харилцааг тусгайлан зохицуулсан хууль байхгүй ч гэсэн даатгалын ерөнхий харилцааг дараах хуулиудаар зохицуулдаг

байна. Үүнд:

- Даатгалын тухай хууль (*Insurance act (2008)*);
- Даатгалын гэрээний тухай хууль (*Insurance Contract Law (2008)*);
- Даатгалын бизнесийн тухай хууль (*Insurance Business Law (1995)*)

Бүгд Найрамдах Азербайжан Улсад албан журмын даатгалын харилцааг *Бүгд Найрамдах Азербайжан Улсын Албан журмын даатгалын тухай хуулиар (Law of the Azerbaijan Republic on Compulsory insurances)* зохицуулдаг. Өөрөөр хэлбэл, албан журмын даатгалын бие даасан хуультай орон юм. Уг хуульд тодорхойлсноор албан журмаар даатгуулах дараах даатгалын төрлүүд байна. Үүнд:

- Үл хөдлөх хөрөнгийн албан журмын даатгал (*Compulsory real property insurance*);
- Үл хөдлөх хөрөнгө ашиглахтай холбоотой гуравдагч этгээдийг хамгаалах хариуцлагын албан журмын даатгал (*Compulsory third party liability insurance associated with the use of the real property*);
- Авто тээврийн хэрэгслийн гуравдагч этгээдийг хамгаалах хариуцлагын албан журмын даатгал (*Compulsory third party liability insurance of motor vehicles*);
- Зорчигчийн гэнэтийн ослын албан журмын даатгал (*Compulsory personal accident insurance of passengers*);
- Хөдөлмөрийн осол болон мэргэжлээс шалтгаалах өвчний улмаас хөдөлмөрийн чадвар алдалтын албан журмын даатгал (*Compulsory insurance against loss of professional work capacity as a result of labor accidents and occupational diseases*);
- Олон улсын зам тээврийн Ногоон картын даатгалын систем (*GREEN CARD*) зэрэг болно.

Түүнчлэн тусгайлсан хуулиар зохицуулагддаг албан журмын даатгалын төрлүүд байна. Тухайлбал, аудиторын мэргэжлийн хариуцлагын албан журмын даатгал, нийгмийн даатгал, эрүүл мэндийн даатгал гэх мэт.

Эдгээрээс гадна төрийн тусгай албан хаагчдад зориулсан дараах албан журмын даатгалын төрлүүд байх ба энэ нь тусгайлсан хуулиар зохицуулагдана. Үүнд:

- Шүүх болон хууль сахиулах байгууллагын албан хаагчдын төрийн тусгай албан журмын даатгал;
- Цэргийн албан хаагчийн төрийн тусгай албан журмын даатгал;
- Гадаад оронд суугаа дипломат ажилтнууд болон гадаад орны байгууллагад ажилладаг ажилтнуудын албан журмын даатгал зэрэг болно.

Бүгд Найрамдах Македон Улсад албан журмын даатгалыг дараах хуулиудаар зохицуулж байна. Үүнд:

- Даатгалын тухай хууль (*Law on Insurance*);
- Замын хөдөлгөөний (албан журмын) даатгалын тухай хууль (*Law on compulsory traffic insurance*);
- Эрүүл мэндийн даатгалын тухай хууль (*Law Health Insurance*);
- Бүрэн санхүүжилттэй тэтгэврийн (заавал) даатгалын сангийн тухай хуулиудаар (*Law on Mandatory fully funded Pension insurance*) зохицуулагдана.

Мөн түүнчлэн “Даатгалын тухай” ерөнхий хуульд заасан дараах албан журмын даатгалын төрлүүд байна. Үүнд:

- Нийтийн тээврийн хэрэгслээр зорчигчдын даатгал;
- Моторт тээврийн хэрэгсэл эзэмшигчийн гуравдагч этгээдэд учруулсан хохирлын хариуцлагын даатгал;
- Агаарын хөлөг эзэмшигчийн гуравдагч этгээдэд учруулсан хохирлын хариуцлагын даатгал;
- Хөдөлгүүрт завь, хөлөг онгоц эзэмшигчийн гуравдагч этгээдэд учруулсан хохирлын хариуцлагын даатгал;

- Төмөр замын тээврийн хэрэгсэл эзэмшигчийн (галт тэрэг, трамвай) гуравдагч этгээдэд учруулсан хохирлын хариуцлагын даатгал гэх мэт.

Мөн эрүүл мэндийн даатгал, замын хөдөлгөөний даатгал, бүрэн санхүүжилттэй тэтгэврийн (заавал) даатгал зэрэг зарим даатгалын төрлүүдийг тусгайлсан хуулиар зохицуулсан байна.

СУДАЛГААНЫ ХЭСЭГ

АЛБАН ЖУРМЫН ДААТГАЛЫН ТӨРӨЛ, ХЭЛБЭР БА ЭРХ ЗҮЙН ОРЧНЫ ТАЛААРХ ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ ТУРШЛАГА

1. БҮГД НАЙРАМДАХ СОЛОНГОС УЛС

Бүгд Найрамдах Солонгос Улсад сайн дурын болон албан журмын гэсэн даатгалын 2 төрөл байна. Албан журмын даатгал нь доорх хэлбэрүүдтэй байна. Үүнд:

- Тэтгэвэр, тэтгэмжийн даатгал (*National pension insurance*);
- Эрүүл мэндийн даатгал (*National health insurance*);
- Урт хугацааны халамжийн даатгал (*Long term care insurance*);
- Үйлдвэрийн ослын нөхөн олговрын даатгал (*Industrial accident compensation insurance*);
- Ажилгүйдлийн даатгал (*Unemployment insurance*);
- Тээврийн хэрэгслийн албан журмын даатгал (*Compulsory automobile liability insurance*) зэрэг болно.

Албан журмын даатгалын эдгээр төрлүүдийг нийтлэг зохицуулсан эрх зүйн акт байхгүй бөгөөд даатгалын төрөл тус бүрийг бие даасан хуулиар зохицуулж байна.

Үндэсний тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль (*National pension act*)³¹⁰

Улсаас олгох тэтгэвэр, тэтгэмж болон Тэтгэвэр, тэтгэмжийн даатгалтай холбогдох харилцааг энэ хууль болон энэ хуулийг хэрэгжүүлэх журам (*Enforcement decree of the national pension act*)-аар тус тус зохицуулна. Өндөр настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг нийгмийн халамжид хамруулж, тэдний амьжиргааг тогтвортой байлгахад тус дэм үзүүлэхэд энэ хуулийн зорилго оршино.

Даатгагдсан иргэдийг ажил эрхлэлтэд суурилсан даатгалд хамрагдсан, хувиараа даатгуулсан, сайн дураар даатгуулсан болон сайн дураараа тасралтгүй даатгуулсан гэж ангилна. 18-60 насны ажилтан болон ажил олгогч нь (*Ерөнхийлөгчийн зарлигаар баталсан тус хуулийг хэрэгжүүлэх журмаар тухайн байгууллагын төрөл болон ажилтнуудын тоо буюу даатгалд хамрагдах шаардлагатай ажлын байрыг тогтооно*) ажил эрхлэлтэд суурилсан даатгалд хамрагдана. Үндэсний тэтгэвэр, тэтгэмжийн алба нь (*National Pension Service*) Үндэсний тэтгэвэр, тэтгэмжийн төсөл (*National Pension Plan*)-д хамрагдах иргэдийг бүртгэн, эрхийг нь баталгаажуулж, иргэдийн сарын орлогод үндэслэн тэтгэмжийн хэмжээг тогтооно. Мөн түүнчлэн Үндэсний тэтгэвэр, тэтгэмжийн төслөөс хасагдаж буй иргэдийн бүртгэлийг хийнэ.

Тэтгэвэр, тэтгэмжийн даатгалын хураамжийн 50%-ийг ажил олгогч, 50%-ийг ажилтан төлөх бөгөөд төлбөрийн хэмжээ нь тус бүр жилдээ 202.050 воноос хэтрэхгүй байна.³¹¹

Эрүүл мэндийн даатгалын тухай хууль (*National health insurance act*)³¹²

Эрүүл мэндийн даатгалтай холбогдох харилцааг энэ хууль болон энэ хуулийг хэрэгжүүлэх журам (*Enforcement decree of the national health insurance act*)-аар тус тус

³¹⁰ https://elaw.klri.re.kr/kor_service/lawView.do?lang=ENG&hseq=45851

³¹¹ <http://www.sungto.co.kr/business-faq/labor-standard-act/social-insurances-four-compulsory-insurances/>

³¹² https://elaw.klri.re.kr/eng_service/lawTotalSearch.do

зохицуулна. Энэ хуулийн зорилго нь иргэдийн эрүүл мэндийг сайжруулах, өвчин эмгэг болон аюул ослоос урьдчилан сэргийлэх, оношлох, эмчлэх, нөхөн сэргээх зорилгоор иргэдийг даатгалын тэтгэмжид хамруулан нийгмийн аюулгүй байдлыг ханган иргэдийн эрүүл мэндийг сахин хамгаалах болно.

Солонгосын нутаг дэвсгэрт оршин сууж байгаа Солонгосын бүх иргэд эрүүл мэндийн даатгалд хамрагдана. Үндэсний эрүүл мэндийн даатгалын алба нь (*National Health Insurance Service*) даатгагдсан иргэдийг баталгаажуулан үнэмлэх олгоно. Тус алба нь эрүүл мэндийн байгууллагуудаар дамжуулан эрүүл мэндийн тэтгэмжийг олгоно.

Даатгалын санхүүжилтийн эх үүсвэрийн дийлэнх хувийг даатгуулагчдаас бүрдүүлэх бөгөөд Засгийн газраас мөн санхүүжилт авдаг байна. Ажил эрхлэгчдийн хувьд даатгалын төлбөрийн 50%-ийг ажил олгогч, үлдсэн 50%-ийг даатгуулагч өөрөө төлнө.

Урт хугацааны халамжийн даатгалын тухай хууль (*Long-term care insurance act*)³¹³

Урт хугацааны халамжийн даатгалыг энэ хууль болон энэ хуулийг хэрэгжүүлэх журам (*Enforcement decree of the long-term care insurance act*)-аар тус тус зохицуулна. Энэ хуулийн зорилго нь өндөр настны эрүүл мэндийг сайжруулах, өндөр настныг тэтгэвэрт гарсны дараа амьжиргааны эх үүсвэрийг тогтворжуулах, өндөр настны ар гэрийнхнийг өндөр настныг асрах, халамжлах үүргээс хөнгөвчлөх зэрэгт урт хугацааны халамжийн тэтгэмжийг зориулахад оршдог байна.

Эрүүл мэндийн даатгалын алба нь Урт хугацааны халамжийн даатгалын хөтөлбөрийг хэрэгжүүлнэ. Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 5 болон 109 дүгээр зүйлд заасны дагуу даатгагдсан иргэн Урт хугацааны халамжийн даатгалд хамрагдаж, тэтгэмж авах эрхтэй байна.

2008 оноос Солонгосын Засгийн газраас орлогогүй, гэр бүлээ асран хамгаалах үүрэгтэй иргэдийн санхүүгийн дарамтыг хөнгөвчлөх үүднээс Урт хугацааны халамжийн даатгалыг хэрэгжүүлж эхэлсэн байна. Ажил эрхлэгчдийн хувьд даатгалын төлбөрийн 50%-ийг ажил олгогч, үлдсэн 50%-ийг даатгуулагч өөрөө төлнө.

Үйлдвэрийн ослын нөхөн олговрын даатгалын тухай хууль (*Industrial accident compensation insurance act*)³¹⁴

Үйлдвэрийн ослын нөхөн олговрын даатгалыг энэ хууль болон энэ хуулийг хэрэгжүүлэх журам (*Enforcement decree of the industrial accident compensation insurance act*)-аар тус тус зохицуулна. Энэ хуулийн зорилго нь үйлдвэрийн осолд орсон ажилчдад нөхөн олговрыг нэн даруй, шударгаар олгох, осолд орсон ажилтнуудыг эмчилж эдгээн, тэднийг буцаад нийгмийн амьдралд ороход шаардагдах даатгалын үйлчилгээг үзүүлэх, ослоос сэргийлэх болон ажилчдын нийгмийн хангамжийг сайжруулахын төлөө төслүүдийг тус даатгалын үйлчилгээгээр дамжуулан хэрэгжүүлэх юм. Хөдөлмөрийн яамны харьяа Солонгосын хөдөлмөр эрхлэгчдийн эрүүл мэнд, нөхөн олговрын асуудлыг хариуцсан байгууллага (*Korea workers' compensation and welfare service*) нь үйлдвэрийн ослын нөхөн олговрын даатгалын хуримтлалыг үүсгэж, даатгалын тэтгэмжийн төрөл болон олгох хэмжээг тодорхойлсны үндсэн дээр тэтгэмжийг олгоно.

Даатгалын тэтгэмжийг доорх байдлаар ангилна. Үүнд:

- 1.Эмчилгээний тэтгэмж;
- 2.Түр хугацааны ажлаас чөлөөлөгдсөний тэтгэмж;
- 3.Хөгжлийн бэрхшээлийн тэтгэмж;
- 4.Асаргаа, сувилгааны тэтгэмж;
- 5.Үлдэгсдийн тэтгэмж;
- 6.Ослоос болон өвчнөөс үүдсэн хохирлын нөхөн төлбөр;
- 7.Оршуулгын зардал;
- 8.Мэргэжлийн нөхөн сэргээх тэтгэмж зэрэг болно.

Эдгээр тэтгэмжийг энэхүү хуулиар эрх нь олгогдсон хүн бүрт тэдний гаргасан

³¹³ https://elaw.klri.re.kr/eng_service/lawView.do?hseq=40189&lang=ENG

³¹⁴ https://elaw.klri.re.kr/eng_service/lawView.do?hseq=41243&lang=ENG

хүсэлтийг үндэслэн олгоно. Даатгалын бүх шимтгэлийг ажил олгогч хариуцна.

Хөдөлмөр эрхлэлтийн даатгалын тухай хууль (*Employment insurance act*)³¹⁵

Ажилгүйдлийн даатгалыг энэ хууль болон энэ хуулийг хэрэгжүүлэх журам (*Enforcement decree of the employment insurance act*)-аар тус тус зохицуулна. Энэ хуулийн зорилго ёсоор ажил эрхлэлтийн даатгалын систем нь ажилгүйдлээс сэргийлэх, ажил эрхлэлтийг дэмжих, ажилчдын мэргэжлийн ур чадварыг хөгжүүлэх, дээшлүүлэх, мэргэжил эзэмшүүлэх болон ажлын байраар хангахад чиглэсэн төрөөс хэрэгжүүлж буй үйлчилгээг дэмжих, ажилгүйдлийн тэтгэмжийг олгосноор ажилгүй болсон иргэдийн амьжиргаанд болон ажил хайхад дэмжлэг үзүүлэх зэргээр эдийн засгийг тогтворжуулж, нийгмийн хөгжилд дэмжлэг үзүүлэхэд оршино. Хөдөлмөр эрхлэлтийн даатгалыг Хөдөлмөрийн яам хариуцна. Хөдөлмөрийн яамны харьяа Хөдөлмөр эрхлэлтийн даатгалын хороо нь хөдөлмөр эрхлэлтийн даатгалын тогтолцоог сайжруулах төсөл, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлнэ.

Хөдөлмөр эрхлэлтийн даатгалын хөтөлбөрүүдэд хөдөлмөрийн аюулгүй байдал болон мэргэжлийн ур чадварыг хөгжүүлэх хөтөлбөрүүд, ажилгүйдлийн тэтгэмжүүд, хүүхэд төрүүлэх болон хүүхэд асарсны тэтгэмж орно.

Тус хуулиар ажилгүйдлийн тэтгэмжийг ажил хайхад зориулсан болон хөдөлмөр эрхлэлтийг дэмжих гэж ангилна. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тэтгэмжийг дотор нь:

1. Дахин хөдөлмөр эрхлэлтийн тэтгэмж;
2. Мэргэжлийн ур чадвараа дээшлүүлэх тэтгэмж;
3. Оршин суудаг газраасаа хол газар ажил хайх тэтгэмж;
4. Тухайн газартаа шилжин суурьшсаны тэтгэмж гэж ангилдаг байна.

Ажил эрхлэгчдийн хувьд даатгалын төлбөрийн 50%-ийг ажил олгогч, үлдсэн 50%-ийг даатгуулагч өөрөө төлнө.

Авто тээврийн ослын нөхөн олговрын тухай хууль (*Guarantee of automobile accident compensation act*)³¹⁶

Автомашин албан журмын даатгалыг (*Compulsory Automobile Liability Insurance*) тус хуулиар зохицуулна. Хуулийн зорилго нь моторт тээврийн хэрэгсэл ашиглах явцад хүний амь нас үрэгдэх, бэртэж гэмтэх, эд хөрөнгө сүйдэх зэрэг осол аюул гарсан тохиолдолд хохирогчийг хамгаалах, нөхөн төлбөр олгох тогтолцоог бий болгож, аюул осолгүй тээврийг хөгжүүлэхэд оршино. Тус хуулиар моторт тээврийн хэрэгсэл эзэмшигч нь моторт тээврийн хэрэгсэл ашиглах явцад тухайн тээврийн хэрэгслийн улмаас гуравдагч этгээд гэмтэж бэртсэн, нас барсан тохиолдолд хохирлыг нөхөн төлөх албан журмын даатгалд хамрагдах болон хариуцлагын харилцан туслалцааны гэрээ байгуулсан байх ёстой гэж заажээ. Хохирлын нөхөн төлбөрийн хэмжээг (Ерөнхийлөгчийн зарлигаар баталсан) тус хуулийг хэрэгжүүлэх журмаар нарийвчлан заана. Албан журмын даатгалд даатгуулаагүй моторт тээврийн хэрэгслээр хөдөлгөөнд оролцохыг хориглоно гэжээ.

Газар нутаг, дэд бүтэц, зам тээврийн яам нь өөрийн харьяандаа Моторт тээврийн хэрэгслийн гэнэтийн ослын хохирлыг барагдуулах агентлагийг (*Moter vehicle accident compensation agency*) байгуулж болно. Тус агентлаг нь авто тээврийн ослын хохирлыг барагдуулах ажилд хяналт тавьж ажиллана.

2. ЯПОН УЛС³¹⁷

Япон улсад албан журмын даатгал нь дараах үндсэн 4 төрөлтэй байна. Үүнд:

- Тээврийн хэрэгслийн даатгал (*Vehicle Insurance*);
- Хувь хүний даатгал (*Personnel Insurance*);
- Нийтийн хариуцлагын даатгал (*Public Liability Insurance*);

³¹⁵ https://elaw.klri.re.kr/eng_service/lawView.do?hseq=41240&lang=ENG

³¹⁶ https://elaw.klri.re.kr/eng_service/lawView.do?hseq=40982&lang=ENG

³¹⁷ <https://www.startupoverseas.co.uk/starting-a-business-in-japan/insurance.html>

- Барилга болон эд хөрөнгийн даатгал (*Building and content insurance*) болно.

Эдгээр албан журмын даатгалын төрлүүдийг ерөнхийд нь зохицуулсан (Албан журмын даатгалын тухай) хууль байхгүй ч гэсэн даатгалын ерөнхий харилцаа болон тусгайлсан харилцааны хувьд дараах хуулиудаар зохицуулж байна³¹⁸. Үүнд:

- Даатгалын тухай хууль (*Insurance act (2008)*);
- Даатгалын гэрээний тухай хууль (*Insurance Contract Law (2008)*);
- Даатгалын бизнесийн тухай хууль (*Insurance Business Law (1995)*) болно.

Даатгалын тухай хууль (*Insurance act 2008*)³¹⁹

Японд даатгалын аливаа харилцааг Даатгалын тухай хуулиар (2008 оны 6 дугаар сарын 6-ны өдрийн №56 хууль) зохицуулна. Тус хууль нь 5 бүлэг 96 зүйлтэй бөгөөд амьдралын бус даатгал, амьдралын даатгалтай холбоотой гэрээ байгуулах, гэрээний үр дагавар, гүйцэтгэл ба дуусгавар болох, осол ба эрүүл мэндийн даатгалын тогтсон дүн зэргийг энэ хууль болон түүнтэй нийцүүлэн гаргасан бусад хууль, журмаар зохицуулж байна.

Хуульд зааснаар даатгалыг амьдралын бус даатгал, амьдралын даатгал гэж хоёр ангилдаг.

Амьдралын даатгал нь хүний амь нас, эрүүл мэндэд эрсдэл тохиолдсон үед даатгуулагчийн орлогыг тасалдалгүй байлгах, улмаар тэдний гэр бүлийн санхүүгийн тогтвортой байдлыг баталгаажуулдаг. Амьдралын даатгал нь хүний амь нас, эрүүл мэндээс гадна хүний амьдрал ахуй, амьжиргааг даатгадаг. Амьжиргаа гэдгийн доор нэмэлт тэтгэвэр, тэтгэврийн даатгалын өв залгамжлал, эрүүл мэндийн онцгой даатгалууд, хуримтлал зэргийг хамруулдаг.

Амьдралын даатгалын эрсдэлийг нас баралтын, насжилтын, эрүүл мэндийн гэж хувааж болох бөгөөд эдгээр эрсдэлтэй холбоотойгоор *амь насны, хуримтлалын, тэтгэврийн, эрүүл мэндийн даатгалын хэлбэрийн бүтээгдэхүүнүүд* байдаг байна.

Дэлхийн амьдралын даатгалын нийт хураамжийн орлогын 32 хувийг Япон Улс бүрдүүлдэг байна. 2013 оны байдлаар тус улсын дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх урт хугацааны буюу амьдралын даатгалын хураамжийн орлогын хувь хэмжээ 8,8 хувь, ердийн буюу амьдралын бус даатгалын хураамжийн хувь хэмжээ 2,2 хувь байжээ.

Амьдралын даатгалын үндсэн нөхцөл нь даатгуулагч бүх төрлийн өвчин, гэнэтийн осол гэх мэт эрсдэлийн улмаас амь насаа алдахад ар гэрт нь даатгалын үнэлгээг бүрэн олгодог. Мөн орон сууцны зээлдэгчийн амь насны даатгал нь энэхүү төрөлд хамаарах бөгөөд зээлдэгч аливаа шалтгааны улмаас амь насаа алдах тохиолдолд тухайн зээлийн үлдэгдлийг нөхөн төлснөөр зээлдэгчийн гэр бүл болон банкыг зээлийн эрсдэлд оруулахгүй байх нөхцөлийг бий болгодог.

Амьдралын бус даатгалд хүний өмч хөрөнгө, хариуцлага, амь нас, эрүүл мэнд, хөдөлмөрлөх чадвартай холбоотой богино хугацааны даатгалуудыг хамруулж байна. Даатгагчаас тухайн хүний эсэн мэнд үлдсэн, эсхүл нас барсантай (гэнэтийн осол ба эрүүл мэндийн даатгалын тогтсон дүн хэмжээ бүхий бодлогыг оролцуулахгүй) холбогдуулан тогтсон даатгалын нөхөн олговор олгох үүрэг хүлээсэн нөхцөлд үүсэх даатгалын бодлого бөгөөд эсэн мэнд гарсан, эсхүл нас барсан бол даатгагдагч даатгалын нөхөн төлбөр авах ёстой.

Гэнэтийн осол ба эрүүл мэндийн даатгалын бодлого нь даатгагчийн зүгээс тухайн хүний гэмтэл, бэртэл, эсхүл өвчний улмаас учирсан хохирлыг (зөвхөн гэмтэл, бэртэл, эсхүл өвчний улмаас учирсан хохирлоор хязгаарлагдана) барагдуулах үүрэг хүлээсэн амь насны бус даатгалын бодлого бөгөөд даатгагчаас тухайн хүнийг гэмтэж бэртсэн, эсхүл өвдсөн тохиолдолд тогтсон хэмжээний даатгалын нөхөн төлбөр олгох үүрэг хүлээж буй бодлого юм.

Даатгалын гэрээний тухай хууль (*Insurance Contract Law 2008*)³²⁰

³¹⁸ <http://www.sonpo.or.jp/en/regulations/001.htm>

³¹⁹ Insurance act http://www.japaneselawtranslation.go.jp/law/detail_main?re=&vm=2&id=2775

Даатгалын гэрээний тухай хууль нь даатгалын гэрээ эзэмшигчид ба даатгалын компаниудын хоорондох даатгалын гэрээтэй холбоотой эрх, үүрэг зэрэг үндсэн асуудлуудыг зохицуулна.

Хуульд зааснаар даатгалын гэрээг ерөнхий даатгал, амь насны даатгал, гэнэтийн осол ба өвчний тогтсон дүн хэмжээ бүхий даатгал гэж ангилаад, даатгалын гэрээг байгуулах, даатгалын тэтгэмжийг төлөх, даатгалын гэрээг дуусгавар болгох үе шатыг тодорхойлсон байна. Үүнд:

1. Даатгалын гэрээг байгуулах (даатгалын гэрээний зорилго, хүлээх үүрэг, даатгалын гэрээг батлах үед бүрдүүлэх баримт бичгүүд);
2. Даатгалын гэрээний хүчин төгөлдөр байдал (гуравдагч талын эрх ашгийн төлөө даатгалын гэрээ, даатгалаас хэтэрсэн даатгал, даатгалын үнэ цэнийг бууруулсан эрсдэлийг бууруулах арга хэлбэр);
3. Даатгалын тэтгэмж (хохирол гарч даамжирахаас урьдчилан сэргийлэх, гарсан хохирлыг мэдүүлэх, даатгагчийн үүрэг хариуцлагаас чөлөөлөгдөх, хохирлын хэмжээг тооцож үнэлэх, даатгалтай байх, давхар даатгалтай байх ба тэтгэмж авах хугацаа);
4. Даатгалын гэрээг дуусгавар болгох (даатгалын гэрээ эзэмшигчийн зүгээс цуцлах, бичиг баримтыг бүрэн бүрдүүлээгүйн улмаас цуцлах, эрсдэл ихэссэний улмаас цуцлах, ноцтой учир шалтгаанаар цуцлах, цуцлах нь үр дүнтэй байх) гэх мэт³²¹.

Даатгалын бизнесийн тухай хууль (Insurance Business Law 1995)³²²

Энэ хуулийн зорилго нь даатгалын бизнесийн нийтийн үүрэг хариуцлагыг тодорхойлж, даатгалын компаниудын менежмент ба даатгалын бүх үйл ажиллагааны тэгш шударга байдлыг баталгаажуулснаар даатгалын гэрээ эзэмшигчдийн ашиг сонирхлыг хамгаалахад оршино.

Тус хууль нь даатгалын компаниуд болон даатгалын өргөдөл гаргах үйл ажиллагааны аль алийг нь зохицуулдаг.

Даатгалын компаниудын үйл ажиллагаа, удирдлагын талаар олон зүйл заалт бий. Үүнд: лиценз олгох шаардлагууд, даатгалын компаниудын хуулийн статус, бизнесийн хүрээ, нягтлан бодох бүртгэлийн асуудлууд, даатгалын бүтээгдэхүүний шалгуурыг нягтлах, даатгалын компаниудын менежмент, тэдгээрийг зохион байгуулах арга хэлбэрүүд, даатгалын компани дампуурсан тохиолдолд даатгалын гэрээ эзэмшигчдийг хамгаалах арга хэмжээ зэргийг зохицуулсан байна. Япон Улсад бизнес эрхэлж буй гадаадын даатгалын компаниудын тухайд ч орон нутгийн компаниудтай адил тэгш байлгах үүднээс ижил заалтууд үйлчилнэ.

Мөн хуульд даатгалын үйлчилгээ эрхлэгчдийг бүртгэх ба зарлан мэдүүлэх, даатгалын үйлчилгээнд хориглох заалтууд, ерөнхий даатгалын агентуудын хяналтыг зохион байгуулах гэх мэт асуудлыг нарийн зохицуулсан байна.

Харин дээрх 4 төрлийн Албан журмын даатгалын харилцааг тус тусдаа бие даасан хуулиудаар зохицуулж байна. Тухайлбал,

- Ажил эрхлэлтийн даатгалын тухай хууль (*Employment insurance act (1974)*)³²³;
- Эрүүл мэндийн даатгалын тухай хууль (*Health Insurance Act (1922)*)³²⁴;
- Үндэсний эрүүл мэндийн даатгалын тухай хууль (*National Health Insurance Act (1958)*)³²⁵;

³²⁰ <http://www.sonpo.or.jp/en/regulations/001.html>

³²¹ Даатгалын гэрээний хууль нь 2010 оны 4 дүгээр сарын 1-ний өдрөөс хүчин төгөлдөр болсон. Тиймээс урьд өмнө Арилжааны тухай хуульд агуулагдаж байсан даатгалтай холбоотой заалтууд хүчингүй болсон.

³²² Insurance Business Law (1995),
<https://www.fsa.go.jp/common/law/ins01.pdf>

³²³ Employment Insurance Act
<http://www.japaneselawtranslation.go.jp/law/detail/?id=1910&vm=04&re=02>

³²⁴ Health Insurance Act
http://www.japaneselawtranslation.go.jp/law/detail_main?re=&vm=02&id=2882

³²⁵ National Health Insurance Act
<http://www.japaneselawtranslation.go.jp/law/detail/?id=2453&vm=04&re=02>

- Автотээврийн аюулгүй байдал, хариуцлагын тухай хууль (*Automobile Liability Security Law (1955)*)³²⁶;
- Газар хөдлөлтийн даатгалын тухай хууль (*Act on Earthquake insurance (1966)*)³²⁷ болно.

Тээврийн хэрэгслийн даатгал

Энэ нь гуравдагч этгээдээс үл хамаарах үхэл, гэмтэл, эд хөрөнгө хохирсон ба гэмтсэн, эдийн засгийн, эсвэл санхүүгийн алдагдал зэрэгтэй холбоотойгоор гаргаж буй нэхэмжлэлийг барагдуулах ба хамгаалах зорилготой албан журмын даатгал юм. Тээврийн хэрэгслийн даатгалтай холбоотой аливаа харилцааг *Автотээврийн аюулгүй байдал, хариуцлагын тухай хууль (Automobile Liability Security Law (1955))*-аар зохицуулах бөгөөд хуулийн зорилго нь ерөнхий даатгалын бизнесийн хөгжлийг дэмжих, амь насны бус даатгалын хувь хэмжээг тогтоогч байгууллагуудыг “эрсдэлийн даатгалын хувь хэмжээ” ба “албан журмын авто машины хариуцлагын даатгал ба газар хөдлөлтөөс үүдэх эрсдэлийн даатгал” зэргийг тооцон тогтоох үед нь үйл ажиллагааг нь баталгаажуулснаар гэрээ эзэмшигчдийн ашиг сонирхлыг хамгаалахад оршино. Японы амь насны бус даатгалын ханш тогтоогч байгууллага нь энэ хуульд үндэслэн байгуулагдсан байдаг.

Энэ хууль нь мөн авто замын ослын хохирогчдын санхүүгийн аюулгүй байдлыг хангана. Хуульд зааснаар Албан журмын автомашины хариуцлагын даатгалын гэрээ байгуулаагүй хэн боловч замын хөдөлгөөнд оролцохыг хориглосон байдаг. Энэхүү гэрээ нь автын осолд орсон хүмүүсийн зөвхөн биеийн гэмтэл, бэртэлийг хамаарч, эд хөрөнгийн хохирлыг хамруулдаггүй.

Тээврийн хэрэгслийн хоёр төрлийн даатгал байдаг ба энэ нь гуравдагч этгээдийн даатгал болон бүрэн даатгал юм. Гуравдагч этгээдийн даатгал нь хохирогчийн хохирлыг барагдуулдаг бол бүрэн даатгал нь жолооч буруутай эсэхээс үл хамааран таны тээврийн хэрэгсэлд гэмтэл гарсан, эсхүл өөрөө өөрийгөө гэмтээсэн, эд хөрөнгөө гэмтээсэн, гал болон хулгайд өртсөн зэрэг тохиолдолд хохирлыг барагдуулна. Япон Улсад энэхүү албан журмын даатгалыг “Албан журмын хяналтын төлбөр” гэх ба өртөг нь хоёр жилд 20.000-50.000 йен байдаг.

Хувь хүний даатгал³²⁸

Энэ нь хүний амь нас, эрүүл мэнд, хөдөлмөрийн чадварт учрах эрсдлээс хамгаалах зориулалт бүхий даатгал юм. Япон Улсын хувь хүний даатгалын бүтээгдэхүүнд:

- Эрүүл мэндийн даатгал;
- Ажил эрхлэлтийн даатгал;
- Орон сууцны даатгал;
- Амь насны даатгал;
- Газар хөдлөлтийн даатгал ордог.

Эрүүл мэндийн даатгалтай холбоотой харилцааг *Эрүүл мэндийн даатгалын тухай хууль (Health Insurance Act (1922))*, *Үндэсний эрүүл мэндийн даатгалын тухай хууль (National Health Insurance Act (1958))*-аар тус тус зохицуулж байна.

Хуульд зааснаар³²⁹ Япон Улсад ажиллаж, амьдарч байгаа хэн боловч заавал эрүүл мэндийн даатгалд хамрагдах ёстой. Эрүүл мэндийн даатгал нь бүх даатгагдсан иргэдийн эмнэлгийн зардлыг төлөх ба удаан хугацааны халамжийн даатгал нь ахмад настнуудын халамжийн тэтгэмжийг олгоно. Үүнд бас хүүхэд төрүүлэх, гэмтэх, өвдөх ба нас барах тохиолдлуудад олгох тэтгэмжүүд багтана. Үндэсний эрүүл мэндийн даатгалд 75-аас доош насны цалингүй оршин суугчид хамрагдана. Ажилтнуудын эрүүл мэндийн даатгалд 75-аас

³²⁶ Automobile Liability Security Law (1955)
http://www.japaneselawtranslation.go.jp/law/detail_main?re=&vm=02&id=2721

³²⁷ Act on Earthquake Insurance
<http://www.japaneselawtranslation.go.jp/law/detail/?id=1888&vm=04&re=02>

³²⁸ Social Insurance in Japan
<http://www.htm.co.jp/payroll-social-insurance-practices-japan.htm>

³²⁹ National Health Insurance Act
<http://www.japaneselawtranslation.go.jp/law/detail/?id=2453&vm=04&re=02>

доош насны цалинтай ажилчид ба тэдний асаргаанд байх 75-аас доош насны хүмүүс хамрагдана. 75-аас дээш насны цалингүй болон цалинтай хүмүүсийн аль аль нь өндөр настны эрүүл мэндийн халамжийн системээр даатгагдана.

Үндэсний эрүүл мэндийн болон ажилтнуудын эрүүл мэндийн даатгалууд нь 70-аас доош насны болон 280,000 йен ба түүнээс дээш стандарт цалин бүхий 70-74 насны хүмүүсийн эмнэлгийн зардлын 70%-ийг төлдөг. Харин 70-74 насны 280,000 йенээс бага, 0 стандарт цалинтай болон 75-аас дээш насны хүмүүсийн эмнэлгийн зардлын 80%-ийг Засгийн газраас төлнө. Хэрвээ нэг гэр бүлийн бүтэн нэг сарын эмнэлгийн зардал дээд хэмжээнээс илүү гарвал тэрхүү давсан хэмжээний мөнгийг нөхөн олгоно. Энэхүү дээд хэмжээг даатгуулагчийн нөхөн төлбөр болон наснаас хамааран тогтооно. Үндэсний эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг өмнөх жилийн орлого ба гэр бүлийн гишүүдийн тоотой харгалзуулан тогтооно.

Япон Улсын эрүүл мэндийн даатгалын тогтолцоо нь даатгуулагчийн төлөх шимтгэлийн хэмжээ орлогоос хамаарч өөр өөр байх хэдий ч үүнээс үл хамааран бүх иргэд тус улсын хаана ч, ямар ч эрүүл мэндийн байгууллагаас ижил чанартай эрүүл мэндийн тусламж үйлчилгээ авдаг, орлого багатай иргэдэдээ чиглэсэн шимтгэлийн хөнгөлөлт болон өндөр үнэтэй эмчилгээнээс хөнгөлөх уян хатан зохицуулалт хийдэг, улсын ба хувийн эмнэлэг гэдгээс үл хамааран өндөр чанартай эмчилгээ үйлчилгээ үзүүлдэг, үйлчлүүлэгч олонтой эмнэлэгт эрүүл мэндийн даатгалын сангаас хөрөнгө илүү зарцуулдаг, тэр нь тухайн эмнэлгийн эмч, эмнэлгийн мэргэжилтнийхээ ур чадварыг үнэлэх цалин урамшууллын үндсэн хүчин зүйл болдог байна.

Үүний зэрэгцээ тус улсын ЭМД-ын тогтолцооны нэг томоохон онцлог нь эмчилгээ, эмийн үнийн тарифийг төрөөс 2 жилд нэг удаа шинэчлэн тогтоодог бөгөөд үүний ач холбогдол нь эрүүл мэндийн нийт зардлыг тодорхой түвшинд барих боломжийг бүрдүүлэх, үүнийн өрсөлдөөнөөс эмчилгээ үйлчилгээний чанарын өрсөлдөөнийг чухалчлах зэрэг олон давуу талтай.

Ажил эрхлэлтийн даатгал нь нийгмийн даатгалын нэгэн төрөл бөгөөд мөн заавал даатгалд ордог. Ажил эрхлэлтийн даатгалын зорилго нь ажилгүйдлийн түвшинг тогтворжуулах, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зорилгоор ажлын байраар хангах, сургалтад хамруулах, ажилгүйдэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх, хөдөлмөр эрхлэлтийн байдлыг нөхөн сэргээх, хөдөлмөр эрхлэх боломжийг нэмэгдүүлэх, ажилчдын чадавхыг хөгжүүлэх, сайжруулах, тэдний нийгмийн халамжийг дэмжих, хөдөлмөр эрхлэлтийн аюулгүй байдлыг хангахад хувь нэмэр оруулах юм.

Энэхүү харилцааг Ажил эрхлэлтийн даатгалын тухай хуулиар зохицуулж байна. Тус хуулиар ажилтны гэнэтийн ослын даатгал, ажил эрхлэлтийн даатгал, ажилгүйдлийн даатгалын нөхөн төлбөр, гэрээ байгуулах, дуусгавар болгох зэрэг бүхий л харилцааг зохицуулсан. Хуульд зааснаар ажилчны гэнэтийн ослын нөхөн төлбөрийн даатгал нь ажил болон аялалтай холбоотой гэмтэл бэртэл, өвчин, үхэл зэргийн эмнэлгийн халамжийн тэтгэмж, эрүүл мэндийн шалтгаанаар 4-өөс дээш хоногийн цалингүй чөлөөний хугацааны нөхөн олговор зэргийг олгоно.

Ажилгүйдлийн даатгал нь ажилгүйдлийн тэтгэмж, тэрчлэн хүүхэд асаргааны болон гэр бүлийн асаргааны чөлөө зэргийн тэтгэмжийг төлнө. Шимтгэлийг ажил олгогчоос төлөх ба хувь хэмжээ нь ажил олгогчийн аж үйлдвэрийн төрөл зүйлээс хамаарч 0.3%-10.3% хооронд өөр өөр байна. Ажил олгогчид хортой нөхцөлийн даатгалын төлбөр болох 0.002%-ийн шимтгэл нэмж олгох ба энэ нь хортой нөхцөлөөс үүдсэн эрүүл мэндийн хохирлын нөхөх олговрын санг бүрдүүлдэг. Ажилгүйдлийн даатгалын тухайд захирлуудад ажилтнуудын нэгэн адил дүрмийг баримтлана.

Ажилгүйдлийн тэтгэмжийг авах хугацааг даатгуулагчийн нас, ажлаас халагдсан шалтгаан, ажилгүйдлийн даатгалын шимтгэл төлсөн хугацаа зэрэгт үндэслэн тогтооно. Анхны тэтгэмжийн төлөлтийг хүлээх хугацаа нь хэрвээ компани нь тухайн ажилтныг ажлаас халсан бол 4 долоо хоног, хэрвээ тухайн хүн өөрийн хүсэлтээр халагдсан бол хүлээх хугацаа гурван сар байдаг байна. Тэтгэмжийг хэрвээ тухайн хүн идэвхтэй ажил хайж байгаагаа нотлож чадвал сар бүр олгодог.

Мөн хуулиар бүх иргэд тэтгэврийн даатгал төлнө. 20-59 насны оюутан, хувиараа хөдөлмөр эрхлэгч, ажилгүй хүмүүсийн төлөх сарын шимтгэлийн үндсэн хэмжээ 16340 йен байх ба энэ хэмжээг жил бүрийн 4 дүгээр сард үнийн өөрчлөлт ба бодит цалингийн индекс зэрэг хүчин зүйлсийг тооцож шинэчлэн тогтооно. 70-аас доош насны цалинтай ажилчид өөрсдийн стандарт цалингийн хувь хэмжээгээр шимтгэл төлнө. 2017 оны 9 дүгээр сарын байдлаар, цалинтай ажилчдын шимтгэлийн хувь хэмжээ 18.30% байсан ба хагасыг нь ажил олгогч, хагасыг нь ажилтан өөрөө төлдөг байна.

Орон сууцны даатгал нь хүний гэр орон болон эд хогшилыг аливаа хохирол, гэмтлээс хамгаалах эд хөрөнгийн даатгал юм. Энэ нь стандарт даатгалд ордог бөгөөд гуравдагч этгээдийн хариуцлага, эрүүл мэндийн нөхөн төлбөр, хууль ёсны төлбөрүүд, гал, ус, салхи шуурга, манан, мөс, цас зэрэг байгалийн гамшгаас үүдсэн гэмтэл хохирлын нөхөн төлбөрүүд багтана. Үндсэн өртөг нь хоёр жилд 25.000-50.000 йений хооронд байна.

Газар хөдлөлтийн даатгал нь албан журмын даатгалд ордог бөгөөд үүнтэй холбоотой харилцааг Газар хөдлөлтийн даатгалын тухай хууль (Act on Earthquake insurance (1966))-аар зохицуулж байна. Энэхүү хуулийг газар хөдлөлтийн үр уршигаар гамшигт нэрвэгдэгсдийн ахуй амьжиргааг тогтвортой болгох зорилгоор баталсан. Хуульд зааснаар газар хөдлөлтөөс үүдэлтэй хохирлыг барагдуулах асуудлыг ердийн бодлогод хамруулдаггүй, харин тусгайлан авч үздэг байна.

Орон сууцны байшин ба эд хогшилд газар хөдлөлтөөс учирсан эрсдэлийг Засгийн газраас хангах ба дахин даатгалын дэмжлэгээр нөхөн төлж барагдуулдаг. Газар хөдлөлтөөс үүссэн гамшиг хохирлын хэмжээ асар их байвал даатгалын хэсэг тус бүрийг бүх хувийн даатгагч ба Засгийн газар хуваан барагдуулах бөгөөд үүнийг Японы газар хөдлөлтийн дахин даатгалын компани зохион байгуулна. Газар хөдлөлтийн даатгалын шимтгэл нь ерөнхийдөө хоёр жилд 5.000-20.000 йен байна.

Амь насны даатгал нь зөвхөн өндөр настанд хамаарах даатгал биш. Энэ нь залуу, эрүүл чийрэг, гэр бүл болоогүй, өөрөөс нь хамааралтай хүнгүй байвч амь насны даатгалаа эхлүүлэх хэрэгтэй байдаг. Энэхүү даатгалын харилцааг Даатгалын тухай хуулиар зохицуулах бөгөөд хуульд зааснаар хүний амь нас, эрүүл мэндэд эрсдэл тохиолдсон үед даатгуулагчийн орлогыг тасалдалгүй байлгах, улмаар тэдний гэр бүлийн санхүүгийн тогтвортой байдлыг баталгаажуулах зорилготой юм.

Ерөнхийдөө эдгээр нь урт хугацаат байнгын даатгал юм. Даатгалын тухай хуулийн 3-р бүлэгт зааснаар даатгуулагч нас барсан тохиолдолд гэр бүл, эсхүл хамаарал бүхий хүмүүст нь нөхөн олговор, тэтгэмжийг бодлогын бичиг баримтад тоймлосон нөхцөлүүдийн хүрээнд харилцан адилгүй өөр өөр даатгалын нөхцөлөөр олгоно.

Харин хөрөнгө оруулалтын төрөл зүйлийн даатгал нь хандив болон бүх насны бодлогыг багтаасан байх ба, шимтгэлээ төлж буй бүх цаг хугацаанд хүчинтэй байна. Үндсэндээ шимтгэлийн зарим хэсгээр хөрөнгө оруулалт хийж өртөг бүтээнэ. Үүнийг даатгуулагчийг нас барахаас ч өмнө бэлэн мөнгөний хэлбэрээр олгох боломжтой.

Нийтийн хариуцлагын даатгал

Даатгуулагч этгээдийн зүгээс гуравдагч этгээдэд учруулсан хохирлыг даатгагчаар нөхөн төлүүлэхээр тохиролцож хийсэн албан журмын даатгал юм. Энэ нь жолоочийн, эмчийн, өмгөөлөгчийн хариуцлагын даатгал гэх мэт олон төрөл байна. Нийтийн хариуцлагын даатгалын харилцааг Автотээврийн аюулгүй байдал, хариуцлагын тухай хууль болон Даатгалын тухай хуулиар тус тус зохицуулдаг.

Барилга болон эд хөрөнгийн даатгал

Энэ даатгал нь хүний эд хөрөнгө, хогшил, эсхүл агуулах нөөц зэргийг гал, ус болон газар хөдлөлт, аянга, шуурга, дэлбэрэлт, хулгай зэрэг бусад хохирлоос хамгаалах зорилготой. Энэхүү даатгалын харилцааг Даатгалын тухай хууль, Газар хөдлөлтийн тухай хууль болон Автотээврийн аюулгүй байдал, хариуцлагын тухай хуулиар тус тус зохицуулдаг байна.

3.ХОЛБООНЫ БҮГД НАЙРАМДАХ ГЕРМАН УЛС (АВСТРИ, ШВЕЙЦАР)

Даатгуулах үүргийг хуулиар тогтоосон даатгалыг албан журмын (заавал хамрагдах) даатгал гэнэ.³³⁰ Олон улс оронд тээврийн хэрэгслийн хариуцлагын даатгал, ажил мэргэжлийн хариуцлагын даатгал болон ялангуяа, нийгмийн даатгалыг албан журмын даатгал (АЖД)-д хамруулдаг байна. Гэхдээ хамгийн гол нь албадан гишүүнчлэлтэй байх төрийн даатгалын систем (ялангуяа нийгмийн даатгал) үү, аль эсхүл хувийн даатгалд заавал даатгуулах үүрэг хүлээсэн байна уу гэдгээрээ л ялгаатай байдаг. Германд гуравдагч этгээдийг хамгаалах зорилгоор хийгддэг даатгал болох тээврийн хэрэгслийн, ажил мэргэжлийн болон анчны хариуцлагын даатгалууд гэж бий. Ажил мэргэжлийн хоршооны хувьд, хөдөлмөрийн ослын эсрэг даатгалын хуулиар энэхүү хамгаалалтыг төрөөс албадан гишүүнчлэлтэй байлгах замаар хэрэгжүүлсэн байдаг.

Хуульчилсан албан журмын даатгал нь Германы Үндсэн хуулийн 2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт тусгагдсан хүний үндсэн эрх болох гэрээ хэлцлийн эрх чөлөөний зарчимтай харшилдаг байдаг. Ийнхүү албан журмын даатгалаар гэрээ хэлцлийн эрх чөлөөг хязгаарлах нь онцгой үндэслэлтэй юм. Тухайлбал, гуравдагч этгээдийг хамгаалах (хариуцлагын даатгалын хувьд), эрүүл мэндийг хамгаалах болон хэрэглэгчийг хамгаалах нь учир шалтгаан мөн.

Даатгалын компанийн хувьд албан журмын даатгал хийхдээ албадан гэрээ байгуулах нь олонтоо. Түүхэнд албан журмын даатгал нь даатгалын монопольтой ихээхэн холбоотой байсан гэж үздэг.

Нийгмийн даатгал

Германд нийгмийн даатгал нь доорх 5 даатгалаас бүрдэнэ.³³¹ Үүнд:

1. Өвчтөний даатгал;
2. Тэтгэврийн даатгал;
3. Ослын даатгал;
4. Ажилгүйдлийн даатгал;
5. Асаргааны даатгал³³² зэрэг болно.

Австрид нийгмийн даатгал нь доорх 4 даатгалаас бүрдэнэ.³³³ Үүнд:

1. Өвчтөний даатгал;
2. Тэтгэврийн даатгал;
3. Ослын даатгал;
4. Ажилгүйдлийн даатгал орно.

Швейцарт нийгмийн даатгал нь доорх 8 даатгалаас бүрдэнэ.³³⁴ Үүнд:

1. Өвчтөний даатгал;
2. Өндөр насны болон тэжээгчээ алдсаны даатгал (ӨНТАД);
3. Ослын даатгал;
4. Ажилгүйдлийн даатгал;
5. Тахир дутуугийн даатгал (ТДД);
6. Ажил мэргэжлийн халамж;
7. Цэргийн ба иргэний алба хаах болон амаржсан үеийн хөдөлмөр орлуулалт;
8. ӨНТАД болон ТДД-ын нэмэлт зэрэг болно.

³³⁰ Албан журмын даатгал-Pflichtversicherung(германаар) <https://de.wikipedia.org/wiki/Pflichtversicherung>

³³¹ Нийгмийн даатгал (германаар) Sozialversicherung (Deutschland (германаар)) [https://de.wikipedia.org/wiki/Sozialversicherung_\(Deutschland\)](https://de.wikipedia.org/wiki/Sozialversicherung_(Deutschland))

³³² Pflegeversicherung (германаар)

³³³ Нийгмийн даатгал (Австри)-Sozialversicherung (Österreich)-германаар [https://de.wikipedia.org/wiki/Sozialversicherung_\(%C3%96sterreich\)](https://de.wikipedia.org/wiki/Sozialversicherung_(%C3%96sterreich))

³³⁴ Нийгмийн даатгал (Швейцар)-Sozialversicherungen (Schweiz)-германаар [https://de.wikipedia.org/wiki/Sozialversicherungen_\(Schweiz\)](https://de.wikipedia.org/wiki/Sozialversicherungen_(Schweiz))

Германд нийгмийн даатгалын эрх зүйн үндсийг Нийгмийн тухай багц хууль (НТБХ) бүрдүүлдэг байна. Нийгмийн даатгалын багц хууль нь доорх хуулиудаас бүрдэнэ. Үүнд:

- Нийгмийн даатгалын бүх салбаруудад хамаарах ерөнхий агуулга: Нийгмийн тухай багц хуулийн 4 дүгээр боть;
- Өвчтөний даатгал: НТБХ-ийн 5 дугаар боть;
- Тэтгэврийн даатгал: НТБХ-ийн 6 дугаар боть;
- Ослын даатгал: НТБХ-ийн 7 дугаар боть;
- Асаргааны даатгал: НТБХ-ийн 11 дүгээр боть;
- Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих: НТБХ-ийн 3 дугаар боть болно.

Аж ахуйн нэгж (ААН)-үүдэд нийгмийн даатгалын шалгалтыг тодорхой давтамжтайгаар тогтмол оруулах замаар энэхүү зохицуулалтуудыг даган мөрдөж байгаа эсэхэд хяналт тавьдаг.

Түүнээс гадна НТБХ-ийн 1 болон 10 дугаар зүйлд тус тус тусгасан ерөнхий зохицуулалтуудыг мөн мөрдөнө. Эзэнт гүрний даатгалын дүрэм³³⁵ (1913-1992 онд германы эрхзүйн тогтолцооны цөм нь байсан)-ийн цөөн зарим заалтыг ч бас мөрддөг.

Нийгмийн даатгалын ихэнх хэсэг нь шимтгэл (гишүүнчлэлийн хураамж)-ээс бүрдэх бөгөөд зарим салбарт төсвөөс (Эрүүл мэндийн сан) санхүүждэг байна.

Австрид нийгмийн даатгалын эрх зүйн орчныг доорх хуулиуд бүрдүүлдэг. Үүнд:

- Нийгмийн даатгалын ерөнхий хууль;
- Тариачны нийгмийн даатгалын хууль;
- Аж ахуй (бизнес) эрхлэгчийн нийгмийн даатгалын хууль;
- Чөлөөт ажил мэргэжил эрхлэгчийн нийгмийн даатгалын хууль;
- Төрийн албан хаагчийн өвчний болон ослын даатгалын хууль;
- Тэтгэврийн ерөнхий хууль.

Австрийн Нийгмийн даатгалын ерөнхий газар нь нийгмийн даатгалын чип карт үйлдвэрлэлт болон ашиглалтын охин компани (ХХК) байгуулсан байдаг. Мөн өвчтөний даатгалын бүх байгууллага мэдээллийн технологийн үйлчилгээ эрхлэх охин компани (ХХК)-тай байдаг. Тариачны болон аж ахуй эрхлэгчийн нийгмийн даатгалын газар нь арын алба³³⁶ хамтран залгуулах зорилгоор конторын удирдлагын ХХК байгуулсан бөгөөд хожим нь төрийн албан хаагчийн болон төмөр зам, уул уурхайн даатгалын газрууд нэгдсэн байна.

Швейцарт нийгмийн даатгалын эрх зүйн орчны үндсийг Швейцарын Холбооны Үндсэн хуулийн 111-114 дэх болон 116-117 дахь зүйлүүд тавьдаг.

111 дэх зүйлд, өндөр нас, тэжээгчээ алдсан болон тахир дутуугийн халамжийг зохицуулах “Гурван-Баганат-Зарчим” нэртэй бүтцийг тодорхойлсон байдаг. 112 дахь зүйлд ӨНТАД болон ТТД, 113 дахь зүйлд ажил мэргэжлийн халамж, 114 дэх зүйлд ажилгүйтлийн даатгал, 116 дахь зүйлд гэр бүлийн нэмэгдэл болон амаржсан эхийн даатгал, 117 дахь зүйлд өвчтөний болон ослын даатгалыг тус тус зохицуулсан байна.

Ийнхүү ӨНТАД болон ТДД, тэдгээрийн нэмэлт нь швейцар-гурван-баганат-системийн эхний багана болох төрийн баганыг илэрхийлдэг бөгөөд хүний үндсэн хэрэгцээг найдвартай хангах зорилготой юм.

Хариуцлагын албан журмын даатгал

Германд хариуцлагын албан журмын доорх даатгалууд бий. Үүнд:

- Тээврийн хэрэгслийн хариуцлагын даатгал (Европын ихэнх улсад);

³³⁵ Reichsversicherungsordnung (германаар)

³³⁶ Backoffice-англиар

- Ажил мэргэжлийн хариуцлагын даатгал (хуулийн өмгөөлөгч, патентын өмгөөлөгч, нотариус, архитектор, инженер, эдийн засгийн захирагч³³⁷ (эдийн засгийн шалган байцаагч болон татварын зөвлөх) болон эмчийн хувьд албан журмын);
- Үйлдвэрлэлийн хариуцлагын даатгал (тодорхой салбар болон аж ахуй эрхлэх чиглэлээр);
- Анчны хариуцлагын даатгал (анчны үнэмлэх олгох нөхцөл болдог);
- Гэрийн амьтан тэжээгчийн хариуцлагын даатгал (тухайлбал, нохой) зэрэг болно.

Германы аялал жуулчлалын эрх зүйд 1994 оноос хойш шинээр тогтсон нэг онцлог гэвэл, аялал жуулчлалын багц³³⁸ үйлчилгээ үзүүлэгч компаниуд нь **дампуурлын үр дагаврын эсрэг албан журмын даатгалд** хамрагдсанаа нотолж аяллын аюулгүй байдлын гэрчилгээ авдаг болсон.

Галын даатгал

Галын даатгал нь дэлхий дээрх хамгийн эртний даатгал бөгөөд Германы Хамбург хотын зөвлөлөөс 1676 онд анх “Хамбургийн галын касс” нэртэйгээр байгуулж байжээ. Үндэс суурийг нь шар айргийн үйлдвэрүүдийн 1591 онд байгуулсан “Хамбургийн галын гэрээ” тавьсан гэж үздэг. Галын даатгал нь анхнаасаа албын журмынх байсан бөгөөд 1994 он хүртэл хэрэгжсэн байдаг. Гэвч Кассел хотод одоо болтол Галын касс ажилладаг бөгөөд 90-ээд оны сүүлчээр орон нутгийн Хадгаламжийн касс (банк)-анд даатгал хэлбэрээр нэгтгэсэн байдаг.³³⁹

Одоо Галаас хамгаалалтын татвар нэртэй болсон бөгөөд Германд муж улсын харин Австрид холбооны улсын татвар (хэдийгээр холбооны татвар боловч мужуудад шууд хуваарилдаг)-т багтдаг байна. Галаас хамгаалалтын татварыг галын даатгал (галын улмаас үйлдвэрлэл зогсолтын даатгалыг оруулан) болон байшин барилга, эд хогшлын даатгал хийгдсэн нөхцөлд шимтгэлд нь ногдуулж авдаг байна.³⁴⁰

Шинэ мянганы эхэн хүртэл **зандалчилал** (терроризм)-аас үүдэлтэй хохирлыг галын даатгалд хамруулдаг байсан боловч 2011.09.11-ний өдрийн үйл явдлаас хойш бүх даатгалын байгууллага уг эрсдэлийг даатгалын гэрээнээсээ түр хасаад байсан юм. Энэ хооронд зандалчилалын эрсдэлийг төрийн оролцоо бүхий “Экстремус-Даатгал” ХК (хувьцаат компани буюу олон нийтийн нийгэмлэг)-д даатгуулж болно. Гэхдээ зөвхөн ААН (аж ахуйн нэгж)-д хамаарах ба хувь хүн хангалттай нөхцөлөөр даатгуулах боломж хараахан бүрдээгүй байгаа болно.³⁴¹

4. БҮГД НАЙРАМДАХ АЗЕРБАЙЖАН УЛС

Азербайжан улсад албан журмын даатгалын харилцааг **Бүгд Найрамдах Азербайжан Улсын Албан журмын даатгалын тухай хуулиар** (*Law of the Azerbaijan Republic on Compulsory insurances*)³⁴² зохицуулдаг. Өөрөөр хэлбэл, албан журмын даатгалын тухай бие даасан хуультай орон юм.

Мөн зарим нэр төрлийн албан журмын даатгалыг тусдаа хуулиар зохицуулдаг. Тухайлбал, аудиторын мэргэжлийн хариуцлагын албан журмын даатгал, нийгмийн даатгал, эрүүл мэндийн даатгал гэх мэт.

Азербайжан улсад албан журмын даатгалын асуудлыг хариуцах үүрэгтэй **Албан журмын даатгалын хороо** ажилладаг. Албан журмын даатгалын хороо нь Бүгд Найрамдах Азербайжан Улсын Иргэний хууль болон Албан журмын даатгалын тухай

³³⁷ Wirtschaftstreuhand (германаар)

³³⁸ Pauschalreise (германаар)

³³⁹ Г.Алтан-Оч нар “Үл хөдлөх хөрөнгийг ‘Галын заавал даатгал’-д хамруулах эрхзүйн зохицуулалтын зарим жишиг, гадаадын туршлага” СТ-14/432 2014 УИХТГ-ын Судалгааны эмхэтгэл-20

³⁴⁰ Мөн тэнд

³⁴¹ Мөн тэнд

³⁴² Бүгд Найрамдах Азербайжан Улсын Албан журмын даатгалын тухай хууль

<http://isb.az/wp-content/uploads/2015/03/LAW-ON-COMPULSORY-INSURANCES-Adopted.pdf>

хуулийн дагуу байгуулагдсан мэргэшсэн үйл ажиллагаа явуулдаг байгууллага бөгөөд даатгуулагч болон гуравдагч этгээд буюу хохирогчийн эрх ашгийг хамгаалах, мөн Албан журмын даатгалын тухай хуульд заасан шаардлагыг хангасан, албан журмын даатгалын тогтолцоог тогтворжуулах, хөгжүүлэх, хууль тогтоомжид заасан бусад үүргийг биелүүлэх зорилготой.

Албан журмын даатгалын тухай хуульд тодорхойлсноор дараах албан журмын даатгалууд байна³⁴³. Үүнд:

- Үл хөдлөх хөрөнгийн албан журмын даатгал (*Compulsory real property insurance*);
- Үл хөдлөх хөрөнгийг ашиглахтай холбоотой гуравдагч этгээдийг хамгаалах хариуцлагын албан журмын даатгал (*Compulsory third party liability insurance associated with the use of the real property*);
- Авто тээврийн хэрэгслийн гуравдагч этгээдийг хамгаалах хариуцлагын албан журмын даатгал (*Compulsory third party liability insurance of motor vehicles*);
- Зорчигчийн гэнэтийн ослын албан журмын даатгал (*Compulsory personal accident insurance of passengers*);
- Хөдөлмөрийн осол болон мэргэжлээс шалтгаалах өвчний улмаас хөдөлмөрийн чадвар алдалтын албан журмын даатгал (*Compulsory insurance against loss of professional work capacity as a result of labor accidents and occupational diseases*);
- Олон улсын зам тээврийн Ногоон картын даатгалын систем (Green Card) зэрэг болно.

Үл хөдлөх хөрөнгийн албан журмын даатгал (*Compulsory real property insurance*)

Үл хөдлөх хөрөнгийн албан журмын даатгалтай холбоотой харилцааг Бүгд Найрамдах Азербайжан Улсын Албан журмын даатгалын тухай хуулийн холбогдох зүйл заалтаар зохицуулна. Галын болон бусад нөхцөл байдлын улмаас үл хөдлөх хөрөнгөд учирсан аливаа эвдрэл, гэмтлийн хохирлыг нөхөн төлөх зорилгоор үл хөдлөх хөрөнгийн албан журмын даатгалыг хэрэглэдэг.

Холбогдох эрх бүхий байгууллагаас гаргасан жагсаалтад заасан барилга байгууламж, орон сууц болон орон сууцны бус зориулалттай үл хөдлөх хөрөнгө, орон сууцны зориулалттай хаус, байшин барилга, мөн төрийн өмчийг заавал даатгуулах ёстой.

Орон сууцтай холбоотой албан журмын даатгал нь барилга байгууламжийн элементүүд, өрөө тасалгаа, хаалга болон цонхны элементүүд, цэвэр бохир усны шугам, хийн хоолой, халаалтын шугам, холбоо, цахилгааны болон бусад шугам утас, гоёл чимэглэлийн элементүүд, бүх төрлийн гадна болон дотор засал чимэглэл, хана, тааз, шал зэрэг бүхий л төрлийн материалууд гэмтсэн тохиолдолд нөхөн олговор олгоно.

Үл хөдлөх хөрөнгийн объектод Азербайжаны хуулиар зөвшөөрөгдөөгүй газар баригдсан, эсвэл засгийн газар болон мужын захиргаанаас нураах шийдвэр гарсан, баригдаж дуусаагүй, аюултай нөхцөл байдалд байгаа үл хөдлөх хөрөнгүүд орно.

Үл хөдлөх хөрөнгийг ашиглахтай холбоотой гуравдагч этгээдийг хамгаалах хариуцлагын албан журмын даатгал (*Compulsory third party liability insurance associated with the use of the real property*)

Үл хөдлөх хөрөнгийг ашиглахтай холбоотой гуравдагч этгээдийг хамгаалах хариуцлагын албан журмын даатгалыг Бүгд Найрамдах Азербайжан Улсын Албан журмын даатгалын тухай хуулиар зохицуулна.

Энэ даатгал нь тухайн үл хөдлөх хөрөнгийг ашиглах явцад, мөн тухайн барилга байгууламжийг барих, засварлах, сэргээн босгох, эсвэл бусад ажлыг гүйцэтгэх үеэр гуравдагч этгээдийн эрүүл мэнд болон эд хөрөнгөд учруулсан хохирлыг нөхөн олгох зорилготой.

³⁴³ <http://isb.az/en/>

Уг даатгалд байшин, барилга байгууламж, орон сууц, мөн хуулийн этгээдийн үйл ажиллагаа явуулж буй байгууламж, талбай болон хувь хүний үйл ажиллагаа явуулах зориулалтаар эзэмшдэг байгууламж, талбай зэрэг үл хөдлөх хөрөнгийг хамруулдаг. Энэ төрлийн үл хөдлөх хөрөнгө эзэмшдэг бол даатгалд заавал даатгуулна.

**Авто тээврийн хэрэгслийн гуравдагч
этгээдийг хамгаалах хариуцлагын албан журмын даатгал**
(*Compulsory third party liability insurance of motor vehicles*)

Уг даатгалтай холбоотой харилцааг Бүгд Найрамдах Азербайжан Улсын Албан журмын даатгалын тухай хуулиар зохицуулна.

Энэхүү даатгалыг Азербайжаны нутаг дэвсгэрт авто тээврийн хэрэгслийг ашиглах явцад хувь хүний эрүүл мэнд болон эд хөрөнгө, мөн хуулийн этгээдийн эд хөрөнгөд учирч болох хохирлыг нөхөн төлөх зорилгоор хэрэглэдэг.

Авто тээврийн хэрэгслийн гуравдагч этгээдийг хамгаалах хариуцлагын албан журмын даатгал нь дараах төрлийн тээврийн хэрэгсэл эзэмшигчдэд хамаарах бөгөөд авто тээврийн хэрэгслийн хөдөлгүүрийн багтаамж нь 50см³-ээс илүү эзэлхүүнтэй байна. Үүнд:

- Зорчигч тээврийн хэрэгсэл болон ижил зориулалттай бусад тээврийн хэрэгсэл;
- Ачааны машин болон ижил зориулалттай бусад тээврийн хэрэгсэл;
- Микро-автобус, автобус болон ижил зориулалттай бусад тээврийн хэрэгсэл;
- Мотоцикл болон моторт дугуйнууд;
- Авто зам, ойн аж ахуй болон хөдөө аж ахуйн зориулалтаар ашигладаг тракторууд;
- Троллейбус, трамвай зэрэг болно.

Зорчигчийн гэнэтийн ослын албан журмын даатгал
(*Compulsory personal accident insurance of passengers*)

Зорчигчийн гэнэтийн ослын албан журмын даатгалтай холбоотой харилцааг Бүгд Найрамдах Азербайжан Улсын Албан журмын даатгалын тухай хуульд заавал даатгуулахаар зохицуулсан. Энэ даатгалыг агаар, ус, төмөр, авто замуудаар зорчих явцад зорчигчдын эрүүл мэнд, амь насанд учирч болзошгүй хохирлыг нөхөн төлүүлэх зорилгоор хэрэглэдэг. Уг даатгалд заавал хамрагдах ёстой.

**Хөдөлмөрийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний
улмаас хөдөлмөрийн чадвар алдалтын албан журмын даатгал**³⁴⁴
(*Compulsory insurance against loss of professional work capacity as a result of labor accidents and occupational diseases*)

Энэ нь Бүгд Найрамдах Азербайжан Улсын Албан журмын даатгалын тухай хуулиар зохицуулагдана. Энэхүү даатгалд даатгуулснаар хөдөлмөрийн осол болон мэргэжлээс шалтгаалах өвчний улмаас амь насаа алдах, эсвэл эрүүл мэндэд хохирол учруулснаар хөдөлмөрийн чадвар алдах тохиолдолд нөхөн олговор олгоно. Уг даатгалд дараах этгээд заавал даатгуулж, даатгалын гэрээ байгуулах үүрэгтэй. Үүнд:

- Азербайжан болон гадаад улсын хууль тогтоомжийн дагуу байгуулагдсан бөгөөд тус улсад үйл ажиллагаа явуулж буй хуулийн этгээд, үүнд албан газар, байгууллага тэдгээрийн салбар, төлөөлөгчийн газар зэрэг нь өмчийн болон зохион байгуулалтын хэлбэр харгалзахгүй хамрагдах;
- Төрийн байгууллагууд;
- Хуулийн этгээд байгуулахгүйгээр аж ахуйн үйл ажиллагаа эрхэлж буй хувь хүн (физические лица, занимающиеся предпринимательской деятельностью без создания юридического лица);
- Сонгуулийн байгууллагууд;
- Аж ахуйн үйл ажиллагаа болон хувиараа хөдөлмөр эрхэлж буй хувь хүн (физические лица, занимающиеся предпринимательской и трудовой деятельностью индивидуальным образом) хамрагдана.

³⁴⁴ <http://isb.az/ru/istehsalatda-bedbext-hadiseler-ve-pese-xestelikleri-neticesinde-pese-emek-qabiliyyetinin-itirilmesi-hallarindan-icbari-sigorta-ru/>

Дараах хүмүүс даатгалд заавал хамрагдах ёстой. Үүнд:

- Бүгд Найрамдах Азербайжан Улсын Хөдөлмөрийн хууль болон Иргэний хуульд заасны дагуу хуулийн этгээд болон аж ахуйн үйл ажиллагаа эрхэлдэг хувь хүнтэй хөдөлмөрийн гэрээ, эсвэл иргэний гэрээ байгуулан ажиллаж буй этгээд, төрийн албан хаагчид, бусад албан хаагчид (Тусдаа хуулиар зохицуулагдах тул цэргийн албан хаагчид, “Шүүх болон хууль сахиулах байгууллагын албан хаагчийн төрийн тусгай албан журмын даатгалын тухай хууль”-ийн 2 дугаар зүйлд заасан байгууллагуудад, мөн “Цэргийн албан хаагчийн төрийн тусгай албан журмын даатгалын тухай хууль”-ийн 2 дугаар зүйлд заасан байгууллагуудад ажилладаг тусгай цолтой этгээд үүнд хамаарахгүй);
- Сонгуульт ажилтай бөгөөд нийгмийн даатгалд заавал хамрагддаг ажилтан (үүнд Парламентын 2 танхимын гишүүд хамаарахгүй) ;
- Үйлдвэрлэлийн дадлагад гарч буй оюутан, сурагчид;
- Аж ахуйн нэгжид ажиллаж буй цэргийн албан хаагчид;
- Байгалийн гамшгаас урьдчилан сэргийлэх, тэдгээрийн үр дагаврыг арилгах ажиллагаанд ажиллаж буй этгээд, мөн дайны болон онцгой нөхцөлд ажиллаж буй этгээд;
- Аж ахуйн үйл ажиллагаа болон хувиараа хөдөлмөр эрхэлж буй хувь хүн;
- Бүгд Найрамдах Азербайжан Улсын Хөдөлмөрийн хуулийн дагуу тус улсад хөдөлмөрлөж байгаа гадаадын иргэн болон харьяалалгүй этгээд нь хөдөлмөрийн гэнэтийн осол, эсвэл мэргэжлээс шалтгаалах өвчний улмаас хөдөлмөрийн чадвараа алдах тохиолдолд уг даатгалд мөн адил хамрагдана (Бүгд Найрамдах Азербайжан Улсын Нийгмийн даатгалын тухай хуулийн дагуу нийгмийн даатгалд заавал даатгуулахгүй гадаад иргэн орохгүй).

Даатгалын гэрээнд хөдөлмөрийн гэнэтийн осол болон мэргэжлээс шалтгаалах өвчний улмаас хөдөлмөрийн чадвар алдах тохиолдолд нөхөн олговрыг холбогдох байгууллагаас зохих журмын дагуу тооцоолсон жилийн цалингийн хэмжээг үндэслэн тогтооно. Нөхөн олговрийг дараах тохиолдолд олгоно. Үүнд:

- Хөдөлмөрийн гэнэтийн осол, эсвэл мэргэжлээс шалтгаалах өвчний улмаас амь насаа алдах;
- Хөдөлмөрийн гэнэтийн осол, эсвэл мэргэжлээс шалтгаалах өвчний улмаас хөдөлмөрийн чадвар алдах зэрэг болно.

Нөхөн олговрыг сар бүр, нэг удаа, нэмэлт гэсэн 3 хэлбэрээр олгодог.

Олон улсын зам тээврийн ногоон картын даатгалын систем (Green card)

Ногоон картын системийг 1949 онд НҮБ-ын Европын Эдийн засгийн Комисс (UNECE)-аас санаачлан боловсруулсан бөгөөд хил дамнасан зам тээврийн хөдөлгөөнийг хөнгөвчлөх зорилготой гаргасан байна.

Энэ нь гишүүн орнуудын хувьд оролцогч талуудын авто тээврийн хэрэгслийн даатгалын гэрээний дагуу гуравдагч этгээдийг хамгаалах хариуцлагын даатгалыг харилцан хүлээн зөвшөөрөх тухай гэрээ юм.

Ногоон картын гэрээнд заасны дагуу гишүүн орны засгийн газраас гаргасан авто тээврийн хэрэгслийн даатгалын гэрээний гуравдагч этгээдийг хамгаалах хариуцлагын даатгал нь гишүүн орнуудын нутаг дэвсгэрт хүчин төгөлдөр гэж тооцогдоно. Одоогийн байдлаар тус гэрээнд 48 орон гишүүнчлэлтэй байна. Гишүүн орон бүрт Ногоон картын Хороо ажилладаг.

Азербайжан Улс нь 2012 онд Ногоон картад нэгдэх хүсэлт гаргаж, гишүүнээр элссэн. Ийнхүү гишүүн орон болсноор Албан журмын даатгалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсан бөгөөд Ногоон карттай холбоотой зохицуулалтуудыг оруулсан. Эдгээр зохицуулалтыг 2016 оны 1 дүгээр сарын 1-нээс даган мөрдөж байна.

Аудиторын мэргэжлийн хариуцлагын албан журмын даатгал (On compulsory insurance of auditors professional liability)

Энэ даатгал нь **Бүгд Найрамдах Азербайжан Улсын Аудиторын мэргэжлийн хариуцлагын албан журмын даатгалын тухай хууль** (*The Law of the Republic of Azerbaijan on compulsory insurance of auditor's professional liability*) буюу тусгайлсан хуулиар зохиулагддаг.

Уг хуулиар Азербайжан улсад аудитын үйлчилгээ явуулдаг хувь хүн болон хуулийн этгээдийн мэргэжлийн хариуцлагын албан журмын даатгалтай холбоотой харилцааг зохицуулах, түүний зохион байгуулалт, эрх зүй болон эдийн засгийн зарчмуудыг тодорхойлно.

Дараах тохиолдлуудыг аудиторын мэргэжлийн хариуцлагын даатгалд хамруулна³⁴⁵. Үүнд:

- Аудитын үйлчилгээний салбарт мөрдөгдөж буй норматив, хууль тогтоомж, стандарт, дүрэм журмын шаардлагыг зөрчих;
- Нягтлан бодох бүртгэл (санхүүгийн) болон татварын тайлангийн алдаа, зөрчилтөй мэдээллийг илрүүлж чадаагүй;
- Илэрсэн алдаа болон зөрчлийг арилгах зөв зохистой зөвлөмж өгч чадаагүй;
- Аудитын ажлыг чанар муутай гүйцэтгэх, ажлыг хугацаанд бүрэн гүйцэт хийж дуусгаагүй;
- Нууцлалын зарчмыг зөрчих зэрэг орно.

Нийгмийн даатгал

Нийгмийн даатгалтай холбоотой харилцааг **Бүгд Найрамдах Азербайжан Улсын Нийгмийн даатгалын тухай хуулиар** (*Закон Азербайджанской Республики О социальном страховании*) зохицуулах бөгөөд нийгмийн даатгалын эрх зүй, эдийн засаг, зохион байгуулалтын үндсийг тодорхойлно.

Нийгмийн даатгал нь заавал даатгуулах (албан журмын даатгал) ба сайн дурын даатгал гэсэн 2 хэлбэртэй байна³⁴⁶. Заавал даатгуулах нийгмийн даатгал нь хөдөлмөрийн гэрээгээр ажиллаж буй бүх этгээдэд хамааралтай. Мөн хуульд заасан бусад этгээд хамрагдана.

Дараах тохиолдлуудад нийгмийн даатгалаас мөнгөн төлбөр олгоно³⁴⁷. Үүнд:

- Тэтгэврийн насанд хүрсэн;
- Хөгжлийн бэрхшээлтэй, эсвэл 18 нас хүртэлх эрүүл мэндийн байдал хязгаарлагдмал иргэн;
- Гэр бүлийн тэжээгчээ алдсан;
- Түр хугацаагаар хөдөлмөрийн чадвар алдсан (хуулиар тогтоосон хугацаанд);
- Жирэмсний;
- Хүүхэд төрүүлсний;
- Хүүхэд асрах;
- Нас барах;
- Сувилал эмчилгээний хэрэгцээнд зэрэг болно.

Эрүүл мэндийн даатгал

Эрүүл мэндийн даатгал нь Бүгд Найрамдах Азербайжан Улсын Эрүүл мэндийн даатгалын тухай хуулиар (*Закон Азербайджанской Республики О медицинском страховании*) зохицуулагддаг. Хуулиар эрүүл мэндийн даатгалын зохион байгуулалт, эрх зүй, эдийн засгийн үндэслэлийг тодорхойлж, эрүүл мэндийн даатгалын субъектуудын хоорондох харилцааг зохицуулна.

³⁴⁵ Аудиторын мэргэжлийн хариуцлагын албан журмын даатгалын тухай хууль, 3 дугаар зүйл http://www.audit.gov.az/uploads/On_compulsory_insurance_of_auditors_professional_liability.pdf

³⁴⁶ Бүгд Найрамдах Азербайжан Улсын Нийгмийн даатгалын тухай хууль, Нэгдүгээр бүлэг, 2 дугаар зүйл https://online.zakon.kz/Document/?doc_id=30596502#pos=29;-168

³⁴⁷ Бүгд Найрамдах Азербайжан Улсын Нийгмийн даатгалын тухай хууль, Нэгдүгээр бүлэг, 4 дүгээр зүйл https://online.zakon.kz/Document/?doc_id=30596502#pos=29;-168

Уг даатгал нь нийгэм хамгааллын үйлчилгээний нэг хэлбэр бөгөөд даатгуулсан тохиолдолд эрүүл мэнд болон эм тарианы тусламж үйлчилгээ авах боломжтой.

Эрүүл мэндийн заавал даатгуулах даатгалаас (албан журмын даатгал) гадна эрүүл мэндийн сайн дурын даатгалтай бөгөөд энэ нь гэрээний үндсэн дээр хүн амыг эрүүл мэнд болон хамааралтай бусад үйлчилгээгээр хангана.³⁴⁸

Эрүүл мэндийн заавал даатгуулах даатгалын асуудлыг хариуцдаг *Төрийн Эрүүл мэндийн Албан журмын даатгалын агентлаг (Государственное Агентство обязательного медицинского страхования)* ажилладаг бөгөөд 2007 онд Ерөнхийлөгчийн зарлигаар байгуулагджээ. Агентлаг нь дараах чиглэлээр үйл ажиллагаа явуулна³⁴⁹. Үүнд:

- Эрүүл мэндийн заавал даатгуулах даатгалын хүрээнд төрийн нэгдсэн бодлогыг хэрэгжүүлэх;
- Хүн амын бүх давхаргыг шаардлагатай эмнэлгийн тусламж үйлчилгээгээр хангах боломжийг сайжруулах;
- Нийгмийн эрүүл мэндийг хамгаалах, дэмжих зорилгоор эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, үр ашгийг дээшлүүлэх арга хэмжээний хэрэгжилтийг хангах зэрэг болно.

Эдгээрээс гадна төрийн тусгай албан хаагчдад зориулсан дараах албан журмын даатгалын төрлүүд байх ба энэ нь тусгайлсан хуулиар зохицуулагдана. Үүнд:

- **Шүүх болон хууль сахиулах байгууллагын албан хаагчийн төрийн тусгай албан журмын даатгал** нь Шүүх болон хууль сахиулах байгууллагын албан хаагчийн төрийн тусгай албан журмын даатгалын тухай хуулиар (*Закон Азербайджанской Республики Об обязательном государственном личном страховании работников судебных и правоохранительных органов*);
- **Цэргийн албан хаагчийн төрийн тусгай албан журмын даатгал** нь Цэргийн албан хаагчийн төрийн тусгай албан журмын даатгалын тухай хуулиар (*Закон Азербайджанской Республики Об обязательном государственном личном страховании работников судебных и правоохранительных органов*);
- **Гадаад оронд суугаа дипломат ажилтнууд болон гадаад орны байгууллагад ажилладаг ажилтнуудын албан журмын даатгал** нь Бүгд Найрамдах Азербайжан Улсаас гадаад оронд суугаа дипломат ажилтнууд болон гадаад орны байгууллагад ажилладаг ажилтнуудын албан журмын даатгалын тухай хуулиар (*Law "On compulsory insurance for officers of diplomatic missions of the Republic of Azerbaijan in foreign countries and international institutions"*) тус тус зохицуулагдана.

5. БҮГД НАЙРАМДАХ МАКЕДОН УЛС

Бүгд Найрамдах Македон Улсад албан журмын (заавал) даатгалын харилцааг дараах хуулиудаар зохицуулж байна. Үүнд:

- Даатгалын тухай хууль (*Law on Insurance*);
- Замын хөдөлгөөний (албан журмын) даатгалын тухай хууль (*Law on compulsory traffic insurance*);
- Эрүүл мэндийн даатгалын тухай хууль (*Law Health Insurance*);
- Бүрэн санхүүжилттэй тэтгэврийн (заавал) даатгалын сангийн тухай хуулиудаар (*Law on Mandatory fully funded Pension insurancy*) зохицуулагдана.

Даатгалын тухай хууль³⁵⁰ (*Law on Insurance*)

Даатгалын тухай хууль нь 2006 оны 1-р сарын 1-ний өдрөөс хүчин төгөлдөр хэрэгжиж

³⁴⁸ Бүгд Найрамдах Азербайжан Улсын Эрүүл мэндийн даатгалын тухай хууль, Нэгдүгээр бүлэг, нэгдүгээр зүйл
http://base.spinform.ru/show_doc.fwx?rgn=2725

³⁴⁹ Государственное Агентство обязательного медицинского страхования
<http://its.gov.az/ru/i-tsda-haqq-nda/umumi-m-lumat/>

³⁵⁰ Македон Улсын Даатгалын тухай хууль, 2006
<http://www.libertas-nstitut.com/de/MK/nationallaws/insurance.pdf>

эхэлсэн, 12 бүлэг, 147 зүйл ангитай. Энэ хуулийн зорилго нь амьдралын болон амьдралын бус даатгалын нөхцөл, давхар даатгал болон албан журмын (заавал) даатгалын үйл ажиллагаа эрхэлж буй даатгалын болон давхар даатгалын компаниуд, брокерын компаниуд, тэдгээрийн үйл ажиллагааг хянах, зохицуулахад оршино. Энэ хуульд заасан журмын дагуу иргэн, хуулийн этгээд даатгалын компанитай даатгалын харилцаанд орох ба Засгийн газар болон хувь хүн, хуулийн этгээд хэрэв хүсвэл эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхээ гадаадын даатгалын компани болон давхар даатгалын компанид даатгуулж болно. Энэ хуулийн 5-р бүлгийн 54-р зүйлд зааснаар дараах **албан журмын (заавал)** даатгалын төрлүүд байна. Үүнд:

- Нийтийн тээврийн хэрэгслээр зорчигчдын даатгал;
- Моторт тээврийн хэрэгсэл эзэмшигчийн гуравдагч этгээдэд учруулсан хохирлын хариуцлагын даатгал;
- Агаарын хөлөг эзэмшигчийн гуравдагч этгээдэд учруулсан хохирлын хариуцлагын даатгал;
- Хөдөлгүүрт завь, хөлөг онгоц эзэмшигчийн гуравдагч этгээдэд учруулсан хохирлын хариуцлагын даатгал;
- Төмөр замын тээврийн хэрэгсэл эзэмшигчийн (галт тэрэг, трамвай) гуравдагч этгээдэд учруулсан хохирлын хариуцлагын даатгал болно.

Энэ хуулийн 5-р бүлгийн 55-р зүйлд зааснаар тээврийн хэрэгсэл эзэмшигч буюу зорчигчид авто замын хөдөлгөөнийг эхлүүлэхээс өмнө даатгалын компанитай албан журмын (заавал) даатгалын гэрээ байгуулна. Автомашины даатгалыг хариуцдаг Үндэсний Даатгалын Агентлаг нь даатгалын нөхцөл, хураамж, шалгуурыг тогтооно.

Нийтийн тээврийн хэрэгслээр зорчигчдын даатгал. Энэ хуулийн 57-р зүйлд зааснаар нийтийн тээврийн үйлчилгээнд бүртгүүлсэн тээврийн хэрэгсэл эзэмшигчид даатгалын компанитай гэрээ байгуулна. Хуулийн 59-р зүйлд зааснаар даатгал төлсөн тохиолдолд амь насаа алдсан бол 1250 евро, хөдөлмөрийн чадвар алдсан тохиолдолд 2500 евро, түр зуур ажиллах чадваргүй болсон тохиолдолд 600 евро тус тус нөхөн олговор олгодог байна (хуулийн 59-р зүйлд).

Моторт тээврийн хэрэгсэл эзэмшигчдийн гуравдагч этгээдэд учирсан хохиролын хариуцлагын даатгал. Энэ хуулийн 61-р зүйлд моторт тээврийн хэрэгсэл, автомашин эзэмшигчийн даатгалд амь нас, эрүүл мэнд нь хохирсон гуравдагч этгээдийн хохирлыг төлөх (автомашины хариуцлагын даатгал) болон тээврийн хэрэгсэл, машины чиргүүлийг даатгаж гэрээ байгуулна. Нийтийн тээврийн замын хөдөлгөөнд оролцож буй бүх хөдөлгүүр, тээврийн хэрэгсэлийг бүртгэлжүүлнэ. 12 сар тутамд техникийн үзлэгт орох ба автомашины хариуцлагын даатгалаас даатгалын гэрчилгээтэй байх, тээврийн хэрэгсэлийн эзэмшигч, жолоочид учирсан хохирлыг хариуцах, тээврийн хэрэгсэлийг жолоодох үедээ осолдсон тохиолдолд нөхөн олговор авах эрхтэй (хуулийн 63-р зүйл). Автомашины хариуцлагын даатгалын хэмжээ нь ачааны бүх тээврийн хэрэгсэл, автобус - 100,000 евро, бүх төрлийн тээврийн хэрэгсэл-50,000 евро тус бүрийг Македон Улсын Үндэсний банкны ханшаар нөхөн олговрыг олгоно (хуулийн 64-р зүйл). Энэхүү хуулийн 65-р зүйлд зааснаар эрүүл мэндийн даатгал, тахир дутуугийн болон тэтгэврийн даатгалын үйл ажиллагаа эрхэлдэг даатгалын компани нь даатгуулсан аж ахуйн нэгжийн эрүүл мэндийн болон бусад зардлыг нөхөн олгох, эрүүл мэндийн даатгалын хуулийг дагаж мөрдөх, тахир дутуугийн болон тэтгэврийн даатгалын хураамжтай холбоотой асуудлуудаар үүрэг хариуцлага хүлээнэ.

Агаарын хөлгийн эзэмшигчдийн гуравдагч этгээдэд учирсан хохиролын хариуцлагын даатгал. Энэ хуулийн 81-р зүйлд агаарын хөлгөөр бүртгүүлсэн агаарын хөлөг эзэмшигчдийн амь нас, гуравдагч этгээдийн эрүүл мэндэд учруулсан хохирол, техникийн эвдрэл гэмтэлтэй холбоотой хохирлыг даатгалын компани нөхөн барагдуулна. Агаарын хөлгөөр зорчиж буй хүмүүсийг гуравдагч этгээд гэж үзнэ. Даатгалын нөхөн олговрыг доорх хүснэгтээс харна уу.

	Агаарын хөлгийн төрөл	Даатгалын дүн (евро)
1.	Агаарын нийтийн тээврийн зорчиж буй барааны жин а) 2,700 кг жинтэй. б) 2,701-аас 5 700 кг жинтэй. в) 5,701-аас 27,000 кг жинтэй. д) 27,001 аас 72,000 кг жинтэй. е) 72,000 кг жинтэй	50,000 100,000 300,000 600,000 1,000,000
2.	Бусад агаарын хөлөг а) цаасан шувуу, хэт хөнгөн гулсалт ба паранер б) Хөдөлгүүр, баллон, хөдөлгүүрт цаасан шувуу, хөдөлгүүртэй нисэх онгоц в) Спортын зориулалтын хөдөлгүүрт агаарын хөлөг иргэдийн хувийн хэрэгцээнд д) Бусад зориулалтаар ашиглагддаг агаарын хөлөг (арилжааны үйл ажиллагаа) захиргааны гүйцэтгэл, эрдэм шинжилгээний ажил, шинжлэх ухааны үйл ажиллагаа, эрүүл ахуйн тусламж, галаас хамгаалах е) Ажилчдын сургалтад ашиглагддаг агаарын хөлөг	3,000 5,000 6,000 25,000 20,000

Македон Улсын агаарын зайд нэвтрэх гадаадын агаарын хөлөг даатгалд хамрагдах ёстой.

Хөдөлгүүрт завь, хөлөг онгоцны эзэмшигчдийн гуравдагч этгээдэд учирсан хохиролын хариуцлагын даатгал. Энэ хуулийн 82-р зүйлд заасны дагуу хөлөг онгоц эзэмшигчид буюу хөдөлгүүртэй завь 1.5 HP-аас дээш даацтай хөдөлгүүртэй завь, бизнес, спорт, зугаа цэнгэлийн зориулалтаар ашиглах хөлөг онгоцыг регистрийн санд бүртгүүлж, хөлөг онгоц буюу хөдөлгүүрт завь эзэмшигч нь гуравдагч этгээдэд учирсан амь нас, бие махбодь, эрүүл мэндийн хохирол, тээвэрлэлтийн эвдрэл, сүйрлийг даатгуулдаг байна. Даатгалын нөхөн олговын хэмжээг дараах хүснэгтээс харна уу. Үүнд:

	Хөлөг онгоцны төрөл	Даатгалын дүн (евро)
1.	хөлөг онгоц, тийрэлтэт хөдөлгүүр, цахилгаан завь (HP 5 хүртэлх даац)	7,500
2.	завь, дарвуулт завь, цахилгаан завь (HP 5-15 даац)	15,000
3.	усан онгоц, завь, хөлөг онгоц, бусад хөлөг онгоцууд (HP 15-50 даац)	40,000
4.	хөлөг онгоц (HP 50 дээш даац)	100,000

Даатгал нь 12 сарын хугацаанд хүчинтэй байна. Гадаад улсын харьяат эзэмшигч гадаад улсад байгаагаа нотлох баримтыг гаргаснаар даатгалын гэрээ байгуулж болно.

Төмөр замын тээврийн хэрэгсэл эзэмшигчдийн гуравдагч этгээдэд учирсан хохирлын хариуцлагын даатгал. Энэ хуулийн 83-р зүйлд төмөр замын тээврийн хэрэгсэл эзэмшигчид тээврийн хэрэгслээ бүртгүүлж, гуравдагч этгээдийн амь нас, бие махбодь, эрүүл мэндэд учирсан хохирлыг барагдуулах зорилгоор даатгалын компанид даатгуулна. Төмөр замын тээврийн хэрэгслээр зорчиж буй хүмүүсийг гуравдагч этгээд гэж нэрлэнэ. Энэ хуулийн 1 дэх заалтыг эзэмшигч, хэрэглэгчдэд хамгийн доод хэмжээ нь 500,000 еврогийн нөхөн олговор олгодог байна.

Замын хөдөлгөөний (албан журмын) даатгалын тухай хууль³⁵¹ (*Law on compulsory traffic insurance*)

Замын хөдөлгөөний (албан журмын) даатгалын тухай хууль нь 2008 онд батлагдсан бөгөөд 9 бүлэг 77 зүйлтэй. Замын хөдөлгөөний даатгал нь заавал даатгалын тухай хуулиар зохицуулагддаг бөгөөд энэ хуульд дараах тээврийн хэрэгслийн эзэмшигчийн даатгалыг хамруулжээ. Үүнд:

- нийтийн тээврийн зорчигчид;
- автомашин, тээврийн хэрэгсэл болон чиргүүл эзэмшигч;
- агаарын хөлөг эзэмшигч;
- хөлөг онгоц, моторт завь эзэмшигч, гуравдагч талуудын учирсан хохирол зэрэг асуудлууд юм.

Тус хуульд зааснаар тээврийн хэрэгсэл эзэмшигч нь хөдөлгөөнд оролцохоосоо өмнө заавал даатгалын компанитай гэрээ хийж, даатгуулсан байхыг шаарддаг. Даатгалын үйл ажиллагаа эрхлэх компани нь тусгай зөвшөөрөлтэй байна. Авто тээврийн хэрэгслийг бүртгэх, бүртгэлийн хугацааг сунгах асуудлыг заавал даатгалын гэрээнд тусгана. Албан журмын даатгалын гэрээний үйл ажиллагаа эрхлэгч нь тээврийн хэрэгсэл эзэмшигчийн зөвшөөрлөөр гэрээ байгуулах ба хуульд заасны дагуу даатгалын нөхцөл, даатгалын хугацаа, эрдсэл, үнэлгээ, ноогдох шимтгэл, тарифыг гэрээнд тусгасан байна.

Нийтийн тээврийн зорчигчдын даатгал³⁵². Нийтийн тээврийн хэрэгслээр зорчигч нь нийтийн тээврээр үйлчлүүлэхдээ заавал даатгал хийлгэсэн байна. Үүнд: Хот хоорондын болон нийтийн, олон улсын нийтийн тээврийн хэрэгсэл автобус, автотээвэр, төмөр зам, хөлөг онгоц, ачаа тээвэрлэх, жуулчин тээвэрлэх хэрэгсэл, онгоц түрээслэх, агаарын хөлөг, тийрэлтэт онгоц зэрэг бүх тээврийн хэрэгслийн үйлчилгээг хамруулна. Хэрэв нийтийн тээврээр зорчиж яваа үед амь насаа алдсан тохиолдолд нийтийн тээврийн даатгалын доод хэмжээгээр тооцно. Нийтийн тээврээр зорчиж байхдаа хөдөлмөрийн чадвар алдсан бол эмчилгээний зардал, нөхөн олговрыг нөхөн төлнө³⁵³.

Энэ хуулийн 44-р зүйлд **Автомашин хариуцлагын Даатгалын Комисс³⁵⁴**-ын үйл ажиллагааг зохицуулсан. Македон Улсын Засгийн газар нь автомашины хариуцлагын даатгалын комиссын гишүүдийг томилох ба комисс нь ерөнхийлөгч, 3 гишүүнээс бүрдэнэ. Комиссын нэг гишүүнийг ерөнхийлөгч, нөгөө гишүүнийг Сангийн Яамны санал болгосны дагуу Даатгалын Хяналтын Агентлаг, нэг гишүүнийг Үндэсний Даатгалын Агентлаг тус тус томилно. Комисс нь автомашины хариуцлагын даатгалын шимтгэлийн тарифын дээд, доод хувь хэмжээг тогтооно. Тарифыг “Төрийн Хэвлэл”-ээр олон нийтэд нийтэлнэ.

Мөн 47-р зүйлд зааснаар **Агаарын хөлөг эзэмшигчийн гуравдагч этгээдийн хариуцлагын даатгал³⁵⁵** нь Бүгд Найрамдах Македон Улсын иргэний агаарын хөлөг эзэмшигч нь бүртгэгдсэн байх ба даатгалын гэрээ байгуулах үүрэгтэй байна. Энэ нь агаарын хөлөгт амь насаа алдах буюу бие махбодь гэмтэх, эрүүл мэндийн хохирол учрах, сүйрэлд орох зэрэг нислэгийн үед гарах аливаа эрсдэлд даатгалын компани нь гуравдагч этгээдийн учирсан хохирлыг бүрэн төлөх үүрэг хүлээнэ. Гадаадын агаарын хөлгийн хувьд Македоны бүсийн агаарын зайд нэвтрэх олон улсын гэрээтэй байна.

Хөлөг онгоц, моторт завь эзэмшигчид гуравдагч этгээдийн хариуцлагын даатгал³⁵⁶ нь амралт чөлөөт цаг, спорт болон бизнес, зугаа цэнгэлийн зорилгоор бүртгүүлсэн хөлөг онгоц, моторт завь эзэмшигчид даатгалын гэрээ байгуулна. Даатгалын гэрээнд гуравдагч этгээдийн амь нас, бие махбодид бэртэл гэмтэл учрах, эрүүл мэндийн хохирол учрах, тээвэрлэлтийн явцад эд зүйлс гэмтэх, устаж үгүй болох зэрэг хохирлуудыг нөхөн төлөхөөр заажээ. Энэ даатгал зорчигчдод хамаарахгүй. Хөлөг онгоц, моторт завь эзэмшигч гуравдагч этгээдийн хариуцлагын даатгалын төлбөрийг Македоны Үндэсний

³⁵¹ Македон Улсын Замын хөдөлгөөний (албан журмын) даатгалын тухай хууль
http://www.aso.mk/dokumenti/regulativa/zakoni/LAW_ON_COMPULSORY_TRAFFIC_INSURANCE_EN.pdf

³⁵² Insurance of passengers in the Public Transport

³⁵³ Македон Улсын Албан журмын (замын хөдөлгөөний) тухай хуулийн хуулийн 10-р зүйл

³⁵⁴ Commission for Automobile Liability Insurance

³⁵⁵ Third party Liability Insurance of Aircraft Owners

³⁵⁶ Third party Liability Insurance of Owners Vessels, that is Motor Boat

Банкны денарын ханшаар тооцно. Гадаад орны хөлөг онгоц, моторт завь эзэмшигч нь моторт завь болон хөлөг онгоц эзэмшдэг гэдгээ нотлох үүрэгтэй³⁵⁷.

Эрүүл мэндийн даатгалын тухай хууль³⁵⁸ (*Law Health Insurance*)

Бүгд Найрамдах Македон Улсын Эрүүл мэндийн даатгалын тухай хуулиар Македон улсын иргэдийг эрүүл мэндийн даатгалд хамруулах болон эрүүл мэндийн даатгалын сангаас үзүүлэх даатгалын үйлчилгээний харилцааг зохицуулсан. Тус улсын хуульд зааснаар эрүүл мэндийн даатгал нь албан журмын (мандатор) болон сайн дурын гэсэн 2 хэлбэртэй байна.

Эрүүл мэндийн албан журмын даатгалыг ил тод, эв санааны нэгдэлтэй, тэгш эрхтэй, үр ашигтай байх зарчмын дагуу зохион байгуулах, иргэдийг энэ хуульд заасан нөхцөлийн дагуу албан журмын даатгалд хамруулах болон эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэх, даатгалын сангаас мөнгөн хэлбэрээр нөхөн олговор олгохтой холбоотой харилцааг зохицуулахад энэ хуулийн зорилго чиглэгдэнэ.

Энэ хууль 1995 онд батлагдсан бөгөөд 5 бүлэг 96 зүйлтэй. Хуульд заасны дагуу эрүүл мэндийн албан журмын даатгалыг Бүгд Найрамдах Македон Улсын Эрүүл мэндийн даатгалын сангаас, сайн дурын эрүүл мэндийн даатгалыг Даатгалын компаниуд хэрэгжүүлнэ.

Энэ хуулийн 1-р бүлэгт *Mandatory health insurance* буюу албан журмын даатгалд (төр болон даатгуулагчаас) хамрагдах этгээдүүдийг тусгайлан заасан байна. Албан журмын даатгалд даатгуулагч этгээд нь даатгуулагч болон түүний гэр бүлийн гишүүд байна. Энэ хэсгийн 5-р зүйлд заасан дараах этгээдүүд заавал даатгалд хамрагдана. Үүнд:

1. Хуулийн этгээдэд ажиллагсад, хувиараа хөдөлмөр эрхлэгчид, төрийн үйлчилгээ эрхэлж байгаа хуулийн этгээд болон институтад ажиллагсад, төрийн албан хаагчид, орон нутгийн өөрөө удирдах байгууллага болон Скопје хотын захиргаанд ажиллагсад;
 - 1а) худалдааны компанийн захирлуудын зөвлөлийн гишүүд, менежментийн багийн гишүүд;
 - 1б) Түр ажилд зуучлах зуучлагчийн тухай хуульд (*Law on Agencies for Temporary Employment*) заасны дагуу түр ажил эрхэлж буй этгээд;
2. Македон Улсын иргэн боловч Македоны газар нутагт үйл ажиллагаа явуулж буй гадаадын хуулийн этгээд, байгууллага, институтад ажиллагсад, Олон улсын гэрээ хэлэлцээрт өөрөөр заагаагүй бол гадаадын дипломат төлөөлөгчийн газар болон консулын албанд ажиллагсад;
3. Хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэн;
4. Хөдөө аж ахуй ба хөдөөгийн хөгжлийн тухай хуульд заасан 2 болон 3-р категорийн хөдөө аж ахуйн холдинг эзэмшигчид;
5. Шашны байгууллагад ажиллагсад;
6. Одоогоор түр ажилгүй байгаа боловч ажилгүйдлийн улмаас даатгалаас мөнгөн хэлбэрээр нөхөн олговор авч байгаа иргэн;
7. Гадаадад хөдөлмөр эрхэлж байгаа бөгөөд тухайн оронд ажиллаж байх хугацаандаа тухайн орны хуулиар, эсвэл олон улсын гэрээ хэлэлцээрийн дагуу эрүүл мэндийн албан журмын даатгалд хамрагдаагүй Македон Улсын иргэн, гэр бүл нь Македон Улсын нутаг дэвсгэрт амьдардаг бол гадаадад хөдөлмөр эрхлэхээсээ өмнө гэр бүлийн гишүүдээ заавал даатгалд хамруулах;

³⁵⁷ Македон Улсын Албан журмын (замын хөдөлгөөний) тухай хуулийн хуулийн 49-р зүйл

³⁵⁸ Македон Улсын Эрүүл мэндийн даатгалын тухай хууль

<http://www.refworld.org/pdfid/5aa125974.pdf>

8. Тэтгэвэр болон тахир дутуугийн тэтгэмжийн хуулийн дагуу тэтгэвэр болон цалин хөлсний нөхөн олговор авагч этгээд;
9. Македон Улстай Нийгмийн даатгалын хэлэлцээрт ороогүй улс орнууд болон Македон улстай нийгмийн даатгалын хэлэлцээрт орсон боловч хэлэлцээрээр эрүүл мэндийн даатгалд хамрагдах эрхийг нь нээж өгөөгүй улс орнуудын даатгалын компаниас өндөр насны тэтгэвэр болон тахир дутуугийн тэтгэмж авдаг, Македон улсын иргэн эх орондоо оршин суух хугацаандаа;
10. Тогтмол санхүүгийн туслалцаа авагч этгээд, хүлээн зөвшөөрөгдсөн цагаачлалын статустай этгээд, асран хамгаалагчийн гэр бүлд байдаг этгээд, нийгмийн хамгаалалын институт (институтын доторхи болон гаднах хамгаалалт)-ын хараа хяналтанд байдаг этгээд, өөр хэн нэгэн хувь хүнээс асаргааны болон мөнгө санхүүгийн нөхөн төлбөр авдаг этгээд, өнчин болон эцэг эхийн халамж асаргаанаас ангид статустай 18 хүртэлх насны хүүхэд, 26 нас хүртэл нийгмийн халамжаас санхүүгийн дэмжлэг авах эрх бүхий этгээд, гэр бүлийн хүчирхийллийн хохирогч бөгөөд Гэр бүлийн тухай хуулийн дагуу хамгаалалтанд авагдсан этгээд, төрийн халамж, дэмжлэгийн тусламжтайгаар бие даан амьдарч байгаа этгээд;
11. Олон улсын гэрээгээр тохиролцсон нөхцөлд хамрагдаагүй, Македон Улсын нутаг дэвсгэр дээр ажил үйлчилгээ эрхэлж буй гадаадын хуулийн этгээд, компани, институт, олон улсын байгууллага, дипломат болон консулын албанд ажиллаж байгаа этгээд;
12. Олон улсын гэрээгээр тохиролцсон нөхцөлд хамрагдаагүй Македон Улсын боловсрол байгууллага болон мэргэжлийн сургалтын байгууллагад элсэн суралцаж байгаа гадаадын этгээд;
13. Өөр нөхцөлөөр даатгуулаагүй шоронд ял эдэлж байгаа этгээд, түр саатуулагдан хоригдож байгаа этгээд, хүүхдийн хорих газарт боловсрол, хүмүүжлийн арга хэмжээнд хамрагдаж байгаа насанд хүрээгүй хүүхэд;
14. Үндэсний чөлөөлөх дайнд (*National Liberation War*) оролцогч, дайнд оролцож тахир дутуу болсон этгээд, дайнд оролцогчид болон дайнд амь үрэгдэгсдийн ар гэр, Дэлхийн 2-р дайнд оролцож тахир дутуу болсон этгээд, Македоны тусгаар тогтнолын төлөөх тэмцэл, үзэл бодлынхоо төлөө хавчигдан гадуурхагдсан, хэлмэгдсэн этгээд иргэд, SFRY (*Socialist Federal Republic of Yugoslavia*)-ийн задралын үеэр дайнд амь үрэгдсэн Македоны иргэн, тэдгээрийн гэр бүлийн гишүүд, эцэг эх;
15. Энэхүү зүйлийн 1-14-т заасан тусгай нөхцөлд хамрагдаагүй Македон улсын иргэд.

Хуулийн 8-р зүйлд эрүүл мэндийн даатгалын сангаас нөхөн олговор олгохтой холбоотой харилцааг зохицуулсан. Македон улсын хуулиар мандатор нөхцөлөөр заавал даатгалд хамрагдсан иргэдэд дараах тохиолдолд нөхөн олговор олгоно. Үүнд:

- ажлын байрнаас гадуур өвдсөн болон бэртэж гэмтсэн тохиолдолд;
- ажил мэргэжлээс шалтгаалах өвчин, ажлын байран дээр бэртэж гэмтсэн тохиолдолд.

Энэ хуулийн 17-р зүйлд зааснаар хөдөлмөрийн чадвараа түр зуур алдсан этгээдэд ажил олгогчоос нөхөн олговрын 70%-ийг, ажлын байран дээр гэмтэж бэртсэн, мэргэжлээс шалтгаалах өвчин туссан, цусны болон эд эрхтэний донор болсон үед болон жирэмсэн байх хугацаанд, хүүхэд төрүүлэх болон асрах хугацаанд энэ хуульд заасны дагуу 100%-ийн цалингийн нөхөн олговор олгоно.

Бүрэн санхүүжилттэй тэтгэврийн (заавал) даатгалын сангийн тухай хууль³⁵⁹
(*Law on Mandatory fully funded Pension insurance*)

Бүрэн санхүүжилттэй тэтгэврийн даатгалын сангийн тухай хууль нь 2003 онд батлагдсан ба 17 бүлэг 146 зүйл ангитай. Энэ хуулиар бүрэн санхүүжилттэй тэтгэврийн даатгалын сан, түүнийг байгуулах болон тэтгэврийн сангийн үйл ажиллагаа, түүний удирдлаган дор үйл ажиллагаа явуулдаг тэтгэврийн компаниуд болон тэтгэвэр тэтгэмж, хөдөлмөрийн чадвар алдалтын даатгалын системтэй холбоотой харилцааг зохицуулна. Эдгээр сан болон компаниудын гол үүрэг нь хуулиар тогтоосон нөхцөлийн дагуу тэтгэврийн сангаас хуваарилагдсан хөрөнгийг санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулах, сангийн хөрөнгийг хуримтлуулах болон хуваарилахад чиглэгдсэн үйл ажиллагаа явуулахад оршино.

Энэ хуульд заасны дагуу Бүрэн санхүүжилттэй тэтгэврийн сангийн үйл ажиллагааг хянан зохицуулах Агентлаг байгуулагдах ба энэ агентлаг нь Тэтгэврийн сан, Тэтгэврийн компаниудад тусгай зөвшөөрөл олгох, үйл ажиллагааг нь хянан зохицуулах үүрэгтэй.

Энэ хуулийн 3-р зүйлд тодорхойлсон “Тэтгэврийн компани” (*Pension Company*), “Тэтгэврийн сан” (*Pension Fund*), “Тэтгэврийн систем” (*Pension Scheme*) зэрэг байгууллагууд тэтгэврийн даатгалын тогтолцоонд тодорхой үүрэг гүйцэтгэнэ. Тэтгэврийн компани гэж тэтгэврийн сангийн менежментийг хэрэгжүүлдэг хувьцаат компани бөгөөд “Универсал тэтгэврийн компани” гэж нэрлэдэг. Тэтгэврийн сан гэж Тэтгэврийн компаниас байгуулж, менежементийг нь хэрэгжүүлдэг Нээлттэй сан (*Open-end Fund*)-г хэлнэ. Бүрэн санхүүжилттэй тэтгэврийн даатгалын санг хянан зохицуулах Агентлаг нь тэтгэврийн компани болон тэтгэврийн сангийн үйл ажиллагаанд хяналт тавина. Кастодиан (*Custodian*) нь тэтгэврийн сангийн данс дахь хөрөнгийг хадгалах болон энэ хуулиар тогтоосон бусад үүргийг хэрэгжүүлдэг Төв банкнаас олгосон лицензтэй банк юм.

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

³⁵⁹ Македон Улсын Бүрэн тэтгэврийн (заавал) даатгалын тухай хууль
<http://www.mse.mk/Repository/UserFiles/File/Misev/Regulativa/Zakoni%20ENG/Revised%20version%20of%20the%20Law%20on%20Mandatory%20Fully%20Funded%20Pension%20Insurance%20June%202006.pdf>

АШИГЛАСАН МАТЕРИАЛ:

- Insurance-related Laws
<http://www.sonpo.or.jp/en/regulations/001.html>
- Insurance in Japan
<https://www.startupoverseas.co.uk/starting-a-business-in-japan/insurance.html>
- Social Insurance in Japan
<http://www.htm.co.jp/payroll-social-insurance-practices-japan.htm>
- Employment Insurance Act
<http://www.japaneselawtranslation.go.jp/law/detail/?id=1910&vm=04&re=02>
- Health Insurance Act
http://www.japaneselawtranslation.go.jp/law/detail_main?re=&vm=02&id=2882
- National Health Insurance Act
<http://www.japaneselawtranslation.go.jp/law/detail/?id=2453&vm=04&re=02>
- Automobile Liability Security Law (1955)
http://www.japaneselawtranslation.go.jp/law/detail_main?re=&vm=02&id=2721
- Act on Earthquake Insurance
<http://www.japaneselawtranslation.go.jp/law/detail/?id=1888&vm=04&re=02>
- Insurance Business Law (1995)
<https://www.fsa.go.jp/common/law/ins01.pdf>
- Insurance act
http://www.japaneselawtranslation.go.jp/law/detail_main?re=&vm=2&id=2775
- Pflichtversicherung
<https://de.wikipedia.org/wiki/Pflichtversicherung>
- Sozialversicherung [https://de.wikipedia.org/wiki/Sozialversicherung_\(Deutschland\)](https://de.wikipedia.org/wiki/Sozialversicherung_(Deutschland))
- Sozialversicherung (Österreich)
[https://de.wikipedia.org/wiki/Sozialversicherung_\(%C3%96sterreich\)](https://de.wikipedia.org/wiki/Sozialversicherung_(%C3%96sterreich))
- Sozialversicherungen (Schweiz)
[https://de.wikipedia.org/wiki/Sozialversicherungen_\(Schweiz\)](https://de.wikipedia.org/wiki/Sozialversicherungen_(Schweiz))
- https://elaw.klri.re.kr/kor_service/lawView.do?lang=ENG&hseq=45851
- <http://www.sungto.co.kr/business-faq/labor-standard-act/social-insurances-four-compulsory-insurances/>
- https://elaw.klri.re.kr/eng_service/lawTotalSearch.do
- https://elaw.klri.re.kr/eng_service/lawView.do?hseq=40189&lang=ENG
- https://elaw.klri.re.kr/eng_service/lawView.do?hseq=41243&lang=ENG
- LAW OF THE AZERBAIJAN REPUBLIC ON COMPULSORY INSURANCES
<http://isb.az/wp-content/uploads/2015/03/LAW-ON-COMPULSORY-INSURANCES-Adopted.pdf>
- Compulsory Insurance Bureau
<http://isb.az/en/>
- Закон Азербайджанской Республики от 18 февраля 1997 года № 250-IQ
О социальном страховании
https://online.zakon.kz/Document/?doc_id=30596502#pos=29;-168
- Закон Азербайджанской Республики от 28 октября 1999 года №725-IQ
О медицинском страховании
http://base.spinform.ru/show_doc.fwx?rgn=2725
- Государственное Агентство обязательного медицинского страхования
<http://its.gov.az/ru/i-tsda-haqq-nda/umumi-m-lumat/>
- Закон Азербайджанской Республики от 5 октября 1999 года № 705-IQ
Об обязательном государственном личном страховании работников судебных и правоохранительных органов
http://base.spinform.ru/show_doc.fwx?rgn=2737
- Закон Азербайджанской Республики от 20 мая 1997 года №296-IQ
Об обязательном государственном личном страховании военнослужащих
http://base.spinform.ru/show_doc.fwx?rgn=19223

- <http://isb.az/ru/istehsalatda-bedbext-hadiseler-ve-pese-xestelikleri-neticesinde-pese-emek-qabiliyyetinin-istirilmesi-hallarindan-icbari-sigorta-ru/>
- Македон Улсын Даатгалын тухай хууль, 2006
<http://www.libertas-nstitut.com/de/MK/nationallaws/insurance.pdf>
- Албан журмын (замын хөдөлгөөний) даатгалын тухай хууль
http://www.aso.mk/dokumenti/regulativa/zakoni/LAW ON COMPULSORY TRAFFIC INSURANCE_EN.pdf
- Македон Улсын Даатгалын тухай хууль, 2006
<http://www.libertas-nstitut.com/de/MK/nationallaws/insurance.pdf>
- Замын хөдөлгөөний (албан журмын) даатгалын тухай хууль
http://www.aso.mk/dokumenti/regulativa/zakoni/LAW ON COMPULSORY TRAFFIC INSURANCE_EN.pdf
- Македон Улсын Эрүүл мэндийн даатгалын тухай хууль
<http://www.refworld.org/pdfid/5aa125974.pdf>
- Бүрэн тэтгэврийн (заавал) даатгалын тухай хууль
<http://www.mse.mk/Repository/UserFiles/File/Misev/Regulativa/Zakoni%20ENG/Revised%20version%20of%20the%20Law%20on%20Mandatory%20Fully%20Funded%20Pension%20Insurance%20June%202006.pdf>